

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-23</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>24-67</i>
<hr/>	
<i>1. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	<i>24-28</i>
<i>2. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>28-28</i>
<i>3. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлүүлэг/</i>	<i>29-67</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Т.Доржханд, Д.Сарангэрэл;
Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Занданшатар, Ж.Сүхбаатар.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 14 цаг 56 минутаас 15 цаг 20 минутад хуралдааныг даргалав.

Нэг. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Д.Энхбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай Улсын Их Хурлын даргын саналыг Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад нэр дэвшигч Д.Энхбат хариулж, тайлбар хийв.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилж, Лувсандоржийн Өлзийсайханыг чөлөөлөх тухай Улсын Их Хурлын даргын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Тогтохсүрэн: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан *Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан*, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч *П.Сайнзориг*, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх *Д.Цолмон*, Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга *Э.Мөнхнасан*, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга *Г.Ганхүү*, Нийслэлийн Газар, зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга *Ж.Ичинноров*, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч *Д.Авирмэд*, “*Нийслэлийн орон сууцны корпораци*” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал *М.Говьсайхан*, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хуулийн хэлтсийн дарга *Д.Энхтуяа* нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх *Г.Алтанцэцэг*, *Ё.Энхсайхан*, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх *Б.Хатантуул*, референт *Э.Баттогтох*, мөн хэлтсийн референт *А.Наранцэцэг* нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн *Г.Ганболд*, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн *Д.Тогтохсүрэн*, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн *Ц.Мөнх-Оргил*, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн *М.Оюунчимэг*, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч *Г.Амартүвшин* нар тус тус танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн тараар:

Төслийн 2, 4, 8, 9, 12, 14, 17, 24, 27 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Одонтуяа, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад *Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан*, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Х.Ганхуяг, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Д.Цогтбаатар /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4.1.5 дахь заалтын “авто замаар” гэсний өмнө “замын хөдөлгөөний эрчим буурч,” гэж нэмж, мөн заалтын “цагаас доош буурч” гэснийг “цагт хүрэхгүй” гэж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “Орон сууцын тухай хуулийн 3.1.3-т заасан орон сууц хөгжүүлэх” гэснийг “гэр хорооллыг барилгажуулах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтыг, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын энэ хуулийн 14.2-т гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9.“автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “**ХОЁРДУГААР БҮЛЭГ**”-ийн гарчгийн “**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛБӨРТЭЙ БҮС, АВТО ЗОГСООЛ**” гэснийг “**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, АВТО ЗОГСООЛ**” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсгийн “шалтгаалан” гэснийг “хамааран” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”** **“НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ”** гэсэн гарчгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Автотээврийн тухай хуулийн 15.1 дэх хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “авто замын даацыг” гэснийг “тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг” гэж өөрчилж, мөн хуулийн 12.2 дахь хэсгийн “тээврийн хэрэгслийн” гэсний өмнө “тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “авто зогсоолыг” гэснийг “автобусны буудал, авто зогсоолыг” гэж, 13.1.3, 13.1.4, 13.5.1, 13.5.4 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “нийтийн” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.5.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“16.4.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 16.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол уг хугацаа дууссанаас хойш 14 хоногт багтаан үнэлгээ хийлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “байршил буюу дэд төвийг түшиглэн” гэснийг “дэд төвийн байршилд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “барилгажилтын төслийг” гэснийг “хот байгуулалтын холбогдох баримт бичгийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “гэрээ байгуулах” гэсний дараа “төслийн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 19.1.5 дахь

заалтын “талбарыг” гэсний өмнө “нэгж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.4, 20.1.5 дахь заалт тус тус нэмэх:

“20.1.4.холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг нэгдсэн удирдлагаар хангах;

20.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “нийслэлийн авто замын даацыг харгалзан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Ерөнхий архитекторын чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар урьдчилан найруулах:

“27.1.Энэ хуулийг 2023 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ГУРАВДУГААР БҮЛЭГ” гэж, “ТАВДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж, “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” гэснийг “ТАВДУГААР БҮЛЭГ” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 9 дүгээр зүйлийн дугаарыг “8” гэж, 10 дугаар зүйлийн дугаарыг “5” гэж, 11 дүгээр зүйлийн дугаарыг “6” гэж, 12 дугаар зүйлийн дугаарыг “9” гэж, 13 дугаар

зүйлийн дугаарыг “7” гэж, 14 дүгээр зүйлийн дугаарыг “10” гэж, 15 дугаар зүйлийн дугаарыг “11” гэж, 16 дугаар зүйлийн дугаарыг “12” гэж, 17 дугаар зүйлийн дугаарыг “13” гэж, 18 дугаар зүйлийн дугаарыг “14” гэж, 19 дүгээр зүйлийн дугаарыг “15” гэж, 20 дугаар зүйлийн дугаарыг “16” гэж, 21 дүгээр зүйлийн дугаарыг “17” гэж, 22 дугаар зүйлийн дугаарыг “18” гэж, 23 дугаар зүйлийн дугаарыг “19” гэж, 26 дугаар зүйлийн дугаарыг “20” гэж, 27 дугаар зүйлийн дугаарыг “21” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

1.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин санал хэлэв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн “цахилгаан тэжээлт автомашин” гэснийг хасах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

11	Цахилгаан тэжээлт автомашин	0-100 000	0-80 000
----	-----------------------------	-----------	----------

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 12.6 дахь хэсгийн “төлбөрийг” гэснийг “төлбөрийн орлогыг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15.9.2 дахь заалтын “боловсон хүчин” гэснийг “хүний нөөц” гэж тус тус өөрчилж, 15.10 дахь хэсгийн “, нэг өнгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 17^{1.5} дахь хэсгийн “олгоно” гэсний өмнө “энэ зүйлийн 17^{1.2}-т заасан журмын дагуу” гэж нэмж, 17^{1.7} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17^{1.7}.Энэ хуулийн 17^{1.5}-д заасан хязгаарт багтаан олгох авто тээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 10.1.10 дахь заалтыг болон мөн зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан” гэж нэмэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.5.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 13.2.9, 22.4-т заасан үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол авто тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хариуцсан газартай” гэснийг “хариуцсан байгууллагатай” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

7.Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалт буюу 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барьсан, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгах зэргээр орц, гарцыг гаргах арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Энэ хуулийн 9.1.7-д заасан барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитектурын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-д заасан мэргэжлийн зэрэгтэй архитектур, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг нийслэлийн ерөнхий архитектурын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргтай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-д заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “70 хувиас” гэсний дараа “илүүгүй” гэж, “60 хувиас” гэсний дараа”илүүгүй буюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Амартүвшин Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтыг 2024 оны 10 сарын 15-ны өдрөөс дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

11.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13.7 дахь хэсгийн “зориулалтыг” гэсний өмнө “хийц, бүтээц” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, С.Амарсайхан нар үг хэлэв.

Төслийн 1, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар” гэснийг “тухайн шатны Засаг даргаар” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “Засаг дарга” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

14.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 35.2.1 дэх заалтыг хасаж, 35.2.2 дахь заалтын дугаарыг 35.2.1 гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.1.амьтны хүрээлэн ажиллуулах журам.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

15.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтын “5 000 000-10 000 000” гэснийг “3 000 000-10 000 000” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

16.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 23.6.11 дэх заалтыг хасаж, 23.6.12 дахь заалтын дугаарыг “23.6.11” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

17.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.2 дахь хэсгийн “12.6.3-г” гэснийг “12.6.3, 12.8-д” гэж, “татварын хэмжээг” гэснийг “татварын хувь хэмжээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

18.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хүртэл” гэснийг “дуустал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бараа” гэснийг “барилгын материал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

19.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.10.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

20.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “22.5.15, 22.5.16 дахь заалт” гэснийг “22.5.18, 22.5.19 дэх заалт” гэж өөрчилж, 22.5.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.5.19.гэр хорооллыг орон сууцжуулах сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

21.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг хасаж, 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Амтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 12.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хамааруулсан нийт газар нутгийн” гэсний өмнө “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

22.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэснийг хасаж, “7.6 дугаар зүйлийн 9. 10” гэснийг “7.6 дугаар зүйлийн 9 “гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

23.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“21.5.4.Энэ хуулийн 21.2.7-д заасан эрх шилжүүлэн авсан бол энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан шийдвэр гаргах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.8.1 дэх заалтын “жагсаалтын эхэнд” гэсний дараа “цахим системд хүсэлт гаргасан огноогоор” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.11 дэх хэсгийн “газар ашиглалтын” гэснийг “эдэлбэр газрын” гэж өөрчилж, “аймаг” гэсний дараа “сум” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 12.4, 12.6 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Энэ хууль батлагдахаас өмнө Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан газар эзэмших, ашиглах хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий этгээд уг хүсэлтийг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

24.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 33.1.5 дахь заалтын “хэмжээг” гэсний өмнө “жишиг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

25.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1.2 дахь заалтыг 1.1, 1.2 дахь дэд заалт болгож, төсөл доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 2.Төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 3, 4 дэх дэд заалт нэмэх:

“3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалтын орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцын байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/ гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Бусад саналын талаар:

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Дээрх хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 25 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим, 14 цаг 56 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга нэг хурал давхцаад байгаа юм байна. Тийм учраас намайг хурал эхлүүлээд явж байгааг гэж хүсэлт тавьсны дагуу би Байнгын хорооны хурлыг удирдахаар боллоо.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна. Ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь гэсэн 11 Их Хурлын гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны ирц бүрдсэн тул 2023 оны 11 дүгээр сарын 28-ны ээлжит хурал нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

1 дүгээрт нь. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал байна.

2-т нь. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Энэ тогтоол хүчингүй болсонд тооцох тухай ийм байнгын хорооны тогтоолын төсөл байна.

3 дугаарт нь. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023 оны 10 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийнэ. Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороод анхны хэлэлцүүлгүүдийг мөн хийсэн, хэлэлцсэн ийм асуудал байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдсанд тооцлоо.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг эхлээд хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд Улсын Их Хурлын даргын бүрэн эрхт 14.1.19 дээр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж, Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ ээ гэж заасан. Үүний дагуу Занданиатар дарга өвчтэй байгаа учраас Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбоотой асуудлаар Улсын Их Хурлын дэд дарга Мөнхбаатар танилцуулга хийнэ ээ. Мөнхбаатар даргыг урьж байна. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд албан бичиг ирсэн байгаа. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилуулах тухай гэсэн 2023 оны 11 сарын 24-нд ийм албан бичиг ирсэн. Үүний дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байгаа юм аа. Ингээд Мөнхбаатар даргыг урьж байна. Мөнхбаатар даргын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Лувсандоржийн

Өлзийсайхан нь өөр албан тушаалд томилогдсон тул Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг шинээр томилох ийм хэрэгтэй болж байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө гэж заасан. Дээрх зохицуулалтын дагуу Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилуулахаар санал болгож байна.

Дамдины Энхбат нь 1981 онд Улаанбаатар хотод төрсөн. 1997 онд Нийслэлийн 78 дугаар дунд сургууль, 1997-2001 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2006-2008 онд Удирдлагын академийг төрийн удирдлагын магистр, 2008-2013 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Их сургуульд докторын зэрэг хамгаалсан.

2009-2013 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн зөвлөх, 2013-2014 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн экспертний албанд ахлах зөвлөх, 2014-2017 онд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ахлах зөвлөх, 2017-2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт Засгийн газрын ахлах референт, 2018-2022 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага зохицуулалтын газарт Засгийн газрын ахлах референт, 2022 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга, мөн оноос Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал харууцсан хэлтсийн даргаар ажиллаж байгаа. Төрийн албанд 15 жил ажилласан, үүнээс 11 жил Улсын Их

Хурлын Тамгын газарт ажиллаж байгаа дадлага туршилагатай төрийн албан хаагч юм.

Иймд улсын Их Хур Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тавигдах хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа тул Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Тогтохсүрэн: Нэр дэвшүүлж, танилцуулга хийсэн Мөнхбаатар даргад баярлалаа. Одоо гишүүд асуулт асууж үг хэлнэ. Асуулт, үг хэлэх журам нэг юм байна.

Дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.2-т гишүүн асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно гэж байна. Тэгэхээр асуулт асууж, үг хэлэх гишүүдийн асуулт асуух гишүүдийн нэрийг эхлээд авъя. Ж.Батсуурь гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Дамдины Энхбат дарга дарга хүрэлцэн ирсэн байна. Нэр дэвшигчээс болон нэр дэвшүүлж байгаа Улсын Их Хурлын дарга, дэд дарга нараас асуулт асууж болно. Ингээд эхлээд Ц.Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын Тамгын газрын даргад нэр дэвшиж байгаа Энхбат танд юуны өмнө баяр хүргэе? 1 асуулт байгаа. Улсын Их Хурал маань саяхан дэлхийн парламентуудаас анх удаа хүний эрхийн мэдрэмжтэй парламент болох тухайд өөрийн үнэлгээгээ амжилттай хийлээ. Мөн жендерийн мэдрэмжтэй парламентын тухай өөрийн үнэлгээгээ амжилттай хийсэн. Энэ ажил бол бас манай

парламентын Төв Азийн гол ардчилсан улс гэдгээрээ парламент маань хүний эрхийн болон жендерийн мэдрэмжтэй ажиллах энэ чиглэлд төрийн байгууллага хууль, тогтоомжоо шинэчлэх ийм манлайлал гаргасан том ажил байгаа. Тэгэхээр энэ Олон Улсын Парламентын холбоо, Монголын Улсын Их Хурлын хамтран хийсэн хүний эрх жендерийн мэдрэмжтэй парламентын өөрийн үнэлгээний энэ ажлын тухайд та хэр амжилттай үргэлжлүүлэн ажиллах вэ. Ер нь парламентын хүний нөөц болон парламентын бусад чадавх дээр хүний эрх жендерийн мэдрэмжтэй байлгах тухайд ер нь ямаршуу бас ажлууд ер нь хийгдэх зүйтэй болов уу гэж үз үзэж байгаа вэ.

Д.Тогтохсүрэн: Асуулт асуулаа. Ажлын хэсгийн 5 номер нэр дэвшигч Энхбат.

Д.Энхбат: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энхбат. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. 76 гишүүнтэй парламентын буюу Улсын Их Хурлын түүх бол ингээд дуусгах үед би 126 гишүүнтэй Улсын Их Хурлын түүх эхлэх энэ чухал хариуцлагатай мөчид Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичиг дарга буюу Улсын Их Хурлын арын албыг дааж ажиллах ийм хүндтэй хариуцлагатай үүргийг авахаар энд ингээд хэлэлцэгдэж байна. Тийм ээ, таны сая хэлсэн асуудал бол олон улсад дэлхий дахинд анхаарлыг татаж хийгдсэн ажил. Тэгээд энэ ажил дээр бол манай өмнөх Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайхан дарга бол маш идэвх зүтгэлтэй ажилласан. Өөрөө бас Улсын Их Хурлын анхны эмэгтэй Ерөнхий нарийн бичгийн дарга байсан. Би өөрөө удирдлагын багт ажиллаж байсан учраас энэ ажлын хэсэгт бас хамт ажиллаж, энэ бүх том ажлын ард Тантай болон бусад Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхээ хамт олонтой ард нь гарсан. Тэгээд энэ бол хүний эрхийн мэдрэмжтэй парламентын хувьд

бол дэлхийд анх удаагаа хийгдсэн ийм үнэлгээ. Жендерийн мэдрэмжтэй парламентын хувьд бол дэлхийн 10-аад оронд бол хийгдсэн юм байна лээ. Ер нь Олон Улсын Парламентын холбоо Олон Улсад бол маш өндрөөр үнэлэгдэж байгаа. Тэгээд Үндэсний болон Олон Улсын экспертүүд маань чухал үнэтэй зөвлөмжүүдийг өгсөн. Энэхүү зөвлөмжүүдийг бол хэрэгжүүлэх тал дээр бол би онцгой анхаарал хандуулж, та бүхэнтэй хамтарч ажиллана гэдгээ илэрхийлье ээ. Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Нэр дэвшиж байгаа Энхбатад амжилт хүсье. Саяхан байх аа, Улсын Их Хурлын Тамгын газрын тайлан Байнгын хороогоор орж ирж байсан. Тэгээд бас өмнөх жилүүдэд хийж байсан ажлын тайланг танилцуулж, бид нар бас сайшааж байсан. Тэгээд сая өөрөө хэллээ. 76 гишүүнээс 126 гишүүн болох энэ эгзэгтэй мөчид Тамгын газрын даргаар ажиллах энэ үүрэг хүлээж байна гэж. Би энэ 76 гишүүдтэй байхад энэ дотор дабль стандарт үйлчлээд байгааг тухайн үед асуугаад, тэгээд тэр талаар гишүүний нэр дээр мэдээлэл, судалгаа ирүүлнэ гэсэн, одоог хүртэл ирээгүй байгаа. Жишээ нь 2020 оны сонгуулиас хойш Улсын Их Хурлын томилолтоор гадаад томилолттой ажилласан хүмүүсийн судалгааг хүргүүлнэ гээд 1 жил орчим болж байна. Одоогоор гар дээр ирээгүй байж байна. Тэгэхээр өнөөдөр 76 гишүүнтэй байхад ийм дабль стандарт үйлчлээд байгаа бол 126 болчихвол бас тэрийг анхаарч ажиллах ёстой байх гэж ингэж бодож байна. Дээр нь би тэр тайлангийн юун дээр Улсын Их Хурлын Тамгын газар бол Улсын Их Хурлын нийт гишүүдийн л Тамгын газар байх ёстой. Аливаа нэг нам бүлгийн гишүүдийг хамаарсан, тэрэнд илүү үйлчилдэг байх ёсгүй гэж бас санаагаа илэрхийлж байсан. Тэр дээрээ бас залуу хүний хувьд, шинэ боловсон хүчний хувьд анхаарч ажиллах ёстой байх. Жишээлэх юм бол, 76 гишүүнээс 3

жил болоход төрийн 3 өндөрлөгийн болон бусад айлчлалаар дээд талын хүн 20, 30 явж байгаа. Зарим гишүүд огт яваагүй байгаа. Жишээ нь миний бие бол Улсын Их Хурлын томилолтоор Эрэн хот ч орж байгаагүй. Асуудал нь бид нар энийг явах, явахгүйдээ гол нь биш. Яагаад вэ гэхээр Тамгын газар асуудалд тэнцвэртэй ханддаг, гишүүдэд тэгш үйлчилдэг ийм зарчим үйлчлэх ёстой гэдэг талаас нь хэлж байсан. Тэгэхээр зэрэг юу гэдэг юм Тамгын газар нь гишүүнийхээ тайлан тавьсан юун дээр гишүүндээ мэдээлэл хүргүүлнэ ээ гээд ингээд 1 жил орчим шахуу алга болчихдог ийм байдлаар явах юм бол 126 гишүүнтэй болох юм бол цаашид бас нөхцөл байдал хүндрэх байх шүү гэж бас зүгээр хэлж ярьж байгаа юм. Тэгээд мэдээж төрийн ажил бол залгамж халаатай байдаг учраас өмнөх тайлан дээр хэлсэн тэр асуулгын асуудал, судалгааг ойрын хугацаанд ирүүлчээрэй гэж хүсэж байна.

Д.Тогтохсүрэн: Санал хэллээ. Батсуурь гишүүн. Тэр гишүүдийн гадаад томилолтын асуудал дээр анхаарах хэрэгтэй байгаа юм шүү Энхбат дарга аа, цаашидаа. Бас нэг жигд явуулах, жигд хандах эд нар юмнууд харагдаад байгаа тэгээд байгаа юм. Зарим гишүүд болохоороо яах вэ нөгөө Их Хурлын Тамгын газраас хамаарахгүй юмнууд байгаа юм. Ерөнхийлөгчийн айлчлал, Ерөнхий сайдын гадаад арга хэмжээ эд нар гээд. Тэд нарт ороод явчхаж байгаа юмнууд байгаа юм. Гэхдээ л ер нь хаагуур явах нь хамаагүй ерөнхийд нь бас энэ гишүүдийг жигд хандах асуудал дээр бас та ерөнхий даргын хувьд бодлого барьж анхаарах ёстой шүү гэдэг санал хэллээ. Асуулт асууж дууслаа.

Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилж, Улсын Их

Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Лувсандоржийн Өлзийсайханыг чөлөөлөх саналыг дэмжье гэснээр санал хураалт явуулах юм байна. Өмнө нь чөлөөлөх тогтоол гаргах байснаа гараагүй юм байна. Тийм учраас заавал тогтоол гарах ёстой юм байна. Нөгөө Их Хурлаас шийдвэрээр томилогдсон учраас. Тийм учраас Энхбатыг томилж, Өлзийсайханыг чөлөөлье гэдгээр саналыг дэмжье гэдэг нь санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож 90% нь дэмжсэн байна. Санал хураалтын дүнг танилцууллаа.

Нэгдсэн хуралдаанд оруулах тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын тогтоол.2023 он

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм одоо тогтоолын төсөл байна. Энэ тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа. Их Хурлын чуулган дээр уншигдаж санал хураагдана.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлаа хэлэлцэн шийдвэрлэлээ. Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

М.Оюунчимэг чуулганы нэгдсэн хуралдаанаар танилцуулна. Баярлалаа.

15.11 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Гишүүд ээ, Төрийн байгуулалтын байнгын хороо өмнөх хуралдаанаараа Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай бид 11 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж 8 дугаар тогтоол гаргасан. Ганболд гишүүнээр ахлуулсан. 2 хүн 1 нь Их Хурлаас нэр дэвшсэн Мягмар гэж хүн байсан. Засгийн газраас нэр дэвшсэн Цэдэвсүрэн гэж 2 хүн дээр сонсгол зохион байгуулах байсан. Гэтэл Их Хурлын даргын нэр дэвшүүлсэн Мягмар өөрөө нэрээ татъя гэж хүсэлт ирүүлсэн. Тийм учраас бол Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчид тогтоох тухай 2023 оны 10 сарын 15-ны 8 дугаар тогтоолыг хүчингүй болгоод, дараагийн нэр дэвшигч тодортол хойшлуулъя гэдэг ийм саналыг оруулж байгаа юм. Ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна.

Тэгвэл тогтоолын төслийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Байнгын хорооны тогтоолыг хүчингүй болгохыг дэмжье санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 80% нь Байнгын хорооны тогтоолыг хүчингүй болгох тогтоолын төслийг дэмжлээ. Санал хураалтын дүнг танилцууллаа. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

15.13 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. 3 дахь асуудал. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн байгаа.

Анхны хэлэлцүүлгийг явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг үндэслэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх бусад Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсьё. Эхлээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно. Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Ганболд гишүүний микрофоныг өгье.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны

дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан газрын асуудлыг хуулийн төсөл дагалдуулан оруулж ирж байгаа нь хэр зохимжтой эсэх, Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газраас өргөн мэдүүлэх Газрын багц хуультай болон хэлэлцүүлгийн шатад байгаа Газрын хуулийн төслүүдтэй нэгтгэн хэлэлцүүлэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал уг хуулийн төсөл нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай хамт баталсан Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцэх эсэх, хуулийн төслийг 2012 сарын 31-ээс өмнө баталснаар нийслэлд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням төсөл зөвхөн Улаанбаатар хотод үүсээд байгаа асуудлыг шийдэх бус, хилийн цэсийн маргаантай бусад аймаг, орон нутгийн асуудлыг давхар шийдэх боломжийг тусгасан эсэх, Нийслэл, дүүргийн төлөвлөлтгүй газар олголтыг хийсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцож, хууль хяналтын байгууллагад шалгуулж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Сервитүүд тогтоож, газар чөлөөлөхөд нийслэлээс үнэгүй авсан болон өндөр үнээр авсан газрын нөхөн төлбөрийн хэмжээг яаж тогтоох талаар, нийслэлийн эдэлбэр газрыг нэмэгдүүлэх нь холбогдох бусад хуультай зөрчилдөх эсэх, маргаан таслах зөвлөл байгуулах нь шаардлагатай эсэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин гэр хорооллын дахин төлөвлөлт, томоохон бүтээн байгуулалтыг шуурхай эхлүүлэх, цаашид бүх шатын Засаг даргын эрх хэмжээг нэмэгдүүлэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн төслийг яаралтай Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Тусгай

хамгаалалттай газар нутагт баригдсан барилга, байгууламжийг тусгай хамгаалалтаас гаргах талаар асуулт асууж, санал хэллээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, зөвхөн Улаанбаатар хотод тулгамдаж байгаа асуудлыг шийдэх бус Улаанбаатарыг тойрсон бусад аймаг, сумдын асуудлыг ч нэгэн адил авч үзэх нь чухал байгааг дурдаад, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хотын ерөнхий төлөвлөгөөндөө тодотгол хийх замаар шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөндөө суурилж Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, газар чөлөөлөх асуудал нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье ээ.

Д.Тогтохсүрэн: Ганболд гишүүнийг дахиад урья. Дахиад тогтоолын төсөлтэй холбогдуулж танилцуулга хийнэ.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн

төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Богд хан уулын дархан цаазат газрын талбайн хэмжээг бууруулахгүйгээр хилийн цэсэд өөрчлөлт оруулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Богд Хан уулын дархан цаазат газрын хилийн цэст өөрчлөлт оруулснаар Төв аймгийн зарим сумдын газар нутагт нөлөөлөх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Богд хан уулын дархан цаазат газрын хилийн цэс, хилийн зааг нь хоорондоо уялдаатай эсэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиар Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах боломж бүрдсэн тул үүнийг хэрэгжүүлж ажиллах талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Н.Энхболд: Ганболд гишүүнд баярлалаа. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Тогтохсүрэн дарга танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллын орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу

хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд нийслэлийн татвар хураамжийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтын болон давхардсан бүтэц, зохион байгуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж ялгаруулах хий өндөртэй эсэхээс хамаарсан татварын шатлал хоорондын зөрөө оновчтой тооцох эсэх, орон нутагт ахисан үйлчилгээ эрхлэхэд 5-10 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж тогтоосон талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир мэргэжлийн холбоонд гэрээний үндсэн дээр тендер шалгаруулах эрхийг өгч байгаа ач холбогдлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нийслэлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг өөрчилж, нийслэлийн хот тохижилт, авто зам, цэвэр, бохир усны ажил болон тэдгээр шаардлагатай техник тоног төхөөрөмжүүдийг тендергүйгээр буюу шууд худалдан авалт хийхээр хуулийн төсөл боловсруулсныг дэмжих боломжгүй тул төсөл санаачлагчид нь буцаах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал бүртгэл, хяналт, зохион байгуулалтыг хуулиар хийж болох хэдий ч орон нутагт такси үйлчилгээ эрхлэхэд улс авах улсын тэмдэгтийн хураамжийг 5-10 сая төгрөгөөр тогтоох нь тус үйлчилгээ эрхлэх борлуулалтын орлогоос ч өндөр дүнтэй байгаад дүн шинжилгээ хийж хуулийн төслийн холбогдох заалтыг эргэн харах, Орон нутагт авто тээврийн хэрэгсэл, техник хяналтын үзлэг, оношилгоо эрхэлдэг аж ахуйн нэгж хэр их байдгийг тооцоо судалгаан дээр судалж дахин нягтлах, Түгжрэлийн

хуулийн төсөлд тусгагдсан замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр ноогдуулах асуудлыг хасах саналыг төсөл санаачлагчид гаргасантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн төслөөс уг төлбөртэй холбоотой заалтыг хасах, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг нэмж I функтээр нэмэгдүүлэх үндэслэл нь ногоон байгууламж стандарт хангаагүй тохиолдолд гэж аливаа нэг стандартгүй байж болохыг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалтыг хуулийн төслөөс хасах, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн 34 дүгээр зүйлд нэмэлт оруулж, Нийслэл хотын үйл ажиллагаатай холбоотой бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад тендергүйгээр шууд гэрээ байгуулах хуулийн төсөл боловсруулсан нь тус хуулийн төслийн үндсэн зарчим бол худалдан авах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимтай нийцэхгүй байхыг анхаарах, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын нэмэлт татвар ноогдуулах асуудал нь Татварын ерөнхий хуулийн нэршилээс зөрүүтэй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дангаараа шинэ төрлийн албан татвар тогтоох хуулийн төсөл боловсруулсан нь Үндсэн хуулиар Улсын Их Хурал татварын дээд, доод хязгаарыг тогтоох эрхэд халдсан хуульд нийцэхгүй байгааг онцгой анхаарах зайлигүй шаардлагын үүднээс уг татварыг нэмэгдүүлэх тохиолдолд Татварын ерөнхий хууль холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт хийх замаар хуулийн хийдлийг арилгах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсөл санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 10 хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Мөнх-Оргил гишүүн танилцуулна.

Ц.Мөнх-Оргил: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр

Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.5 дахь хэсгийг баримтлан 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан журмын дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол гаргасан бөгөөд саналын томъёоллыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахаас өмнө газар чөлөөлөлтийн болон такси

үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал дээр Улсын Их Хурлын Тамгын газрын эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээр эрх зүйн дүгнэлт хийлгэх талаар санал хэлж, мөн автобусны хүртээмж, дулаан зогсоолын асуудал болон томоохон хотхонуудын дундах сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос илүү стандарт тогтоох, Стандарт шаардлага хангасан этгээд хэн нэгнээс үл хамааран тусгай зөвшөөрөл олгогддог байх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэхийн тулд нээлттэй сонголт хийж үр дүнг зөвшөөрлийн Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлсэн байх шаардлагыг хангасан эсэх, хотхонуудын дундах газрыг чөлөөлж сургууль, цэцэрлэг барих боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаагүй бөгөөд дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүнд баярлалаа. Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, Төсөв, Хууль зүй, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтүүдийг сонсож дууслаа. Одоо ажлын хэсгийн санал сонсоно.

Түүнээс өмнө ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Хуралдаанд оролцож байгаа Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Сайнзориг, Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон, Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга Ганхүү, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Батзориг байна уу. Батзориг хаачсан. Сайнзориг дарга аа. Газар зохион байгуулалтын холбоотой асуудал ч гарна шүү. Хэлтсийн дарга Ихбаяр, Нийслэлийн Газар, зохион

байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ичинноров, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хуулийн хэлтсийн дарга Энхтуяа, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Хан-Уул ирээгүй байна. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төслийн зохицуулагч Авирмэд, Нийслэлийн орон сууцын корпорац компанийн гүйцэтгэх захирал Говьсайхан. Ийм хүмүүс өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

Одоо энэ хуулиудын талаар хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа ажлын хэсэг гарсан. Амартүвшин гишүүнээр ахлуулсан. Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулна.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад даргалагчаас дээрх хуулийн төслүүд төслийг холбогдох Байнгын хороонд хороодын хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсөн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор дээрх хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг

бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Бат-Эрдэнэ, Ганхуяг, Мөнх-Оргил, Одонтуяа, Оюунчимэг, Сарангэрэл, Цогтбаатар нарыг тус тус томилуулан ажиллууллаа.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 3 удаа, ажлын дэд хэсэг 6 удаа хуралдаж, хуулийн төслийн төсөлтэй нэг бүрчлэн танилцаж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн санал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтүүдийг хэлэлцлээ. Ажлын хэсэг дээрх хуулийн төсөлд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлд нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгслийн дугаарын хязгаарлалт хийх, авто зогсоолын зохицуулалт, стандарт тогтоох ажлыг нэн тэргүүнд хийхээр тусгаж, эдийн засгийн буюу татварын бодлогын хөшүүргийг ашиглан замын хөдөлгөөний төлбөртэй бүс тогтоох, төлбөр хураамж авах асуудлыг төслөөс хасахаар шийдвэрлэлээ.

Хуулийн төслийг өргөн барьснаас хойш Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа зарим хуулийн төсөлтэй тухайлбал Гэрийн тэжээвэр амьтны тухай болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй нийцүүлэх саналуудыг мөн бэлтгэлээ.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан Нийслэл хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үерийн далан сувгийн засвар арчилгаа, хог хаягдалтай холбоотой бараа ажил үйлчилгээ худалдан авах болон Нийслэл хотод

шаардлагатай машин техник, тоног төхөөрөмж, бараа материалыг санхүүгийн түрээс лизингээр худалдан авах бол гэрээ шууд байгуулахаар тусгагдсан заалтыг хасах нь зүйтэй гэж үзлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 174 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан 68 зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн та бүхэнд танилцуулахаар тараасан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Амартүвшин гишүүнд баярлалаа. Одоо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлнэ. Гишүүд зүйлтэй холбогдуулж хууль санаачлагчаас болон бусад оролцогч нараас асуулт асууж болно. 4 минутаас илүүгүй хугацаатай. Шаардлагатай бол 1 минутаас илүүгүй хугацаатайгаар асуулт асууж, хариулт авна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Дахиад сануулъя тухай тухайн зүйлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуулт асууж болно. Та бүхэнд ажлын хэсгийн саналын томъёолуудыг тараасан байгаа. Асуудлаа хэлэлцэж эхэлье. 70 орчим санал хураана. Санал хураалт эхэлье.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай

гишүүн байна уу. Ажлын хэсгийн томъёоллоор санал хураагаад явж байгаа. Том хууль, дагалдах хуулиуд нь дараа нь явна.

Төслийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс доорх санал орж ирсэн. Уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.” Санал гаргасан Амартүвшин, Бат-Амгалан, Бат-Эрдэнэ, Ганхуяг, Мөнх-Оргил, Одонтуяа, Оюунчимэг, Сарангэрэл, Цогтбаатар нарын гишүүд цаашид “ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. 11 гишүүнээс 8 дэмжиж 72.7 хувийн санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Амарсайхан гишүүн байна. 2 дээр дээр. Ажлын хэсэг бэлдэж байгаарай. Х

С.Амарсайхан: Би энэ хуулийн Засгийн газрын хуралдаанаар орж ирэхэд нь ерөнхийд нь энэ замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, хотын хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх хууль орж ирж байна гэж дэмжсэн. Гэтэл энэ хууль дээр бас анхаарах ёстой цааши нь нарийвчилж үзэх ёстой олон асуудал байгаад байна. Ер нь бол энэ өөрөө хууль нэр нь их сайхан хууль. Гэхдээ нидэр дээрээ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зүйл заалтуудын эрх олгосон заалтуудыг зүгээр цуглуулаад ингээд хийчихсэн ийм л төсөл болчихоод байна л даа. Нийслэлийн эрх зүйн

байдлын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гээд Үндсэн хуулийн энэ байгууллагад олгочихсон эрхийн хүрээнд бүх зохицуулалтыг хийгээд явчих боломжтой. Гэтэл дахиад энэ байгаа хуулиудаа нэгтгээд ингэж дахиж давхар хуульчлах гээд байгааг ерөөсөө ойлгохгүй байгаад байна.

Тухайлбал энэ нийслэлийн Засаг дарга замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарлалтыг тогтоож уг бүсэд мөрдөх журмыг батална гэхчхэн мөртөө энэ нь болохоор одоо байгаа саяын миний ярьдаг хуулиудаар ингээд зохицуулагдчихсан асуудал байгаад байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ нийтийн тээврийг хөгжүүлэх сан гэж хийнэ гээд байгаа юм. Бид өмнөх сангуудынхаа будилаан хулгай луйвруудтай бас цэгцэлж амжаагүй л яваад байгаа шүү дээ. Тэгээд төсөв дээрээ зохицуулаад хийчих юмыг заавал тусгай сан байгуулж ийм зохицуулалт хийх ямар шаардлага байна вэ.

3 дугаарт нь энэ төрийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд өөрчлөлт оруулна гээд. Зам барьсан, ч хот тохижилт байсан ч, тэгээд дулаан, дэд бүтэц гээд хийхгүй ажил бүх ажлыг шууд гэрээгээрээ хийнэ гэхчхэн байгаа юм. Ингээж зохицуулах юм бол бид энэ төрийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль гэж байх хэрэг байгаа юм уу. Үүний чинь цаана жинхэнэ хяналтгүй, зохион байгуулалтгүй, чанаргүй, стандартгүй, хулгай луйврын асуудал явна. Ямар учраас ийм заалт оруулж ирж байгаа юм бэ.

Дахиад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулна гэж байна. Аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурал гэдэг бол бас л Үндсэн хуулийн байгууллага. Өөрийн тогтсон дэг жаягтай. Явж ирсэн уламжлал Үндсэн хууль болон бусад хуулиар Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжсийн тухай хуулиар олгогдсон, бүрэн эрхтэй ийм байгууллага. Тэгээд ийм байгууллагын 1 дүгээрт эрхэнд нь халдаад, 2 дугаарт нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаагаа явж ирснээс нь салгаад Засаг дарга дээр авна гээд ингээд оруулж ирж байгаа. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Энэ хууль чинь өөрөө аюулгүй байдлыг, хөдөлгөөний зохицуулалтыг л хангах тухай хууль болохоос биш энэ дээр төлбөр төлөх үүргийг нэмж хүлээлгэх ийм заалт хүртэл орчихсон явж байгаа юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг гэсэн хэсэгт замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг хугацаанд төлөх үүргийг нэмж хүлээлгэхээр тусгасан байгаа юм. Гэтэл энэ чинь санхүү, төлбөр тооцоо, татвар хураамжийн зохицуулалтын тухай хууль биш шүү дээ. Тэгээд миний мэдэхийн энэ хууль чинь хуулийн нэлээн мэдлэгтэй, ойлголттой, туршлагатай хүмүүс боловсруулж оруулж ирсэн хууль гэж бол ойлгож байгаа. Гэтэл энэ хуулийг нь гээд аваад үзчих, хүлээн зөвшөөрчих заалт үндсэндээ энэ дотор байхгүй байгаад байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Хэн хариулах вэ. Ажлын хэсэг. Яах вэ, зүгээр би нэг энэ чинь уг нь бид нар саяын жишээ нь миний 2 дугаар зүйл дээр гэж санал хураалгаж байгаа зүйл бол Засгийн газраас оруулж ирсэн юмыг ерөөсөө өөрчлөх тухай асуудал энд байхгүй шүү дээб Засгийн газрын...тэгвэл юу Амараа сайд аа, яг тэр хуулийнхаа тэр тэр заалтууд дээр яриад явъя тэгэх үү. Тэгээд хариулаад явчихъя. Тэгэхгүй бол энэ дээр чинь яг Засгийн газраас орж ирсэн бүхэлд нь ороод ирчихсэн яг 2 дугаар зүйл дээр юм байхгүй болохоор бас хариулахад төвөгтэй болчихоод байх шиг байна. Тэгэхээр яг саяынхаа асуудлуудыг та

тухай тухайн зүйлүүд дээр асуугаад явчихаарай. Тэгж тохирох уу Амараа сайд аа. Баярлалаа.

2 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал байхгүй. Зарчмын зөрөөтэй санал гараагүй учраас 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Төслийн 3 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй бол 3 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр гишүүдээс асуулт санал алга байна. Ажлын хэсгээс энэ дээр санал орж ирсэн байгаа. Үүний дагуу санал хураана.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтыг, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын энэ хуулийн 14.2-т гэснийг тус тус хасах. Санал хураалт. Саяын саналыг 7 гишүүн дэмжиж, 63,6%-аар дэмжлээ.

4 дүгээр зүйл дээр бас нэг санал байгаа.

Төслийн 4.1.5 дахь заалтын “авто замаар” гэсний өмнө “замын хөдөлгөөний эрчим буурч,” гэж нэмж, мөн заалтын “цагаас доош буурч” гэснийг “цагт хүрэхгүй” гэж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “Орон сууцны тухай хуулийн 3.1.3-т заасан орон сууц хөгжүүлэх” гэснийг “гэр хорооллыг барилгажуулах” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. 8 гишүүн дэмжиж, 72,7%-аар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9. “автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.” Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 7 гишүүн дэмжиж, 63,6%-аар санал дэмжигдлээ. Үүгээр 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 5 дугаар зүйл дээр санал гишүүдээс санал байхгүй. Ажлын хэсгээс санал гарсан.

Төслийн 5 дугаар зүйлийг бүхэлд нь хасах санал гарсан байгаа. Санал хураалт. 7 гишүүн дэмжиж,

6 дугаар санал. Төслийн **“ХОЁРДУГААР БҮЛЭГ”-ийн гарчгийн “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛБӨРТЭЙ БҮС, АВТО ЗОГСООЛ”** гэснийг **“НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, АВТО ЗОГСООЛ”** гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн дараа шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 8 гишүүн дэмжиж, 72,7%-аар саналыг дэмжлээ.

Төслийн 6 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал ирсэн. Төслийн 6 дугаар зүйлийг хасах саналыг дэмжье гэсэн санал хураалт тавиулъя. 72,7%-аар санал дэмжигдлээ. 6 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийг хасах саналыг ажлын хэсгээс оруулсан. Санал хураалт явуулъя. Тоогий дарга аа. Саяын таны хэлдэг энэ чинь хуульд зүйл зүйлээр гэсэн болохоор бид нар бас өчигдөр баахан ярьсан юм. Заавал тэрийг нь уншихгүй бол зөрчигдөх гээд, Дэгийн хууль зөрчигдөх гээд байна гээ. Тэр байтугай нэг зүйлийг зохицуулсан бүтэн юм байгаа. Тэрийг бүхэлд нь хасчихъя гэхээр тэрнээс болоод түрүүнд нь Байнгын хорооны ажилтан бас хууль зөрчсөн зүйлүүд. Тэрийг дараа нь ярья.

7 дугаар зүйл. Санал хураалт. Дэлгэрсайхан гишүүн чинь манай Байнгын хороо биш билүү тэр 2. Тийм байна. 81,8 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар зүйл. Мөн хуулийн 8 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй. Ажлын хэсгээс 8 дугаар зүйлийг хасах санал гаргасан. Тогтохсүрэн гишүүн горимын санал

гаргая. Тогтохсүрэн гишүүний микрофон өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа.

Тэгэхээр яах вэ, одоо нэгэнт санал хураагаад дуусаж байгаа учраас ингээд дуусгачих нь зөв байх. Байнгын хороо дээр бол. Нэгдсэн чуулган дээр энэ 6, 7, 8-ыг нэгтгээд хураачхаж болох заалт байхгүй юу. Яагаад гэхээр энэ 3 заалт 1 зохицуулалт байхгүй юу. Өөрөөр хэлбэл төлбөртэй бүс гэдгийн л зохицуулалтууд байхгүй юу. Нэг нь төлбөр тогтоож байгаа, нөгөөдөх нь төлбөрөө яаж авах вэ, 3 дахь нь ингээд. Тэгэхээр хэрэв эд нарыг тус тусад нь хурааж байгаа нь бол яваандаа бол ер нь буруу юм болох юм байгаа юм. Магадгүй Их Хурал дээр ингээд нөгөө гишүүд янз бүрийн байдлаар хандаад нэгийг нь дэмжчихээд, 2 дахийг нь хасъя гэсэн дэмжигдэхгүй үлдчихвэл яах юм. Тийм учраас энэ 3-ыг бол дандаа нэгтгэж явж байх ёстой. Ер нь бид нар дэгийн хуульд ч гэсэн энийг манай Тамгын газрынхан бодно биз. Бодож үзэж байх ёстой асуудал учраас би бол Байнгын хороо дээрээ ингээд хураачихъя. Нэгдсэн чуулган дээр бол 6, 7, 8-ыг нэгтгээд хураачихъя гэдэг ийм санал хэлж байгаа юм.

Н.Энхболд: Үгүй ээ, наадхыг чинь ажлын хэсэг ч анхаарсан, Тогтохсүрэн дарга ч анхаарч байна. Бид нар ч өчигдөр Байнгын хорооны ажлын хэсэг дээр ярьсан юм. Тэгээд хууль нь ийм юм гээд ярьж байгаа. Ер нь яах вэ маргааш санал тавьж болно. Яг үнэхээр тийм байхгүй юу. Энэ юмыг бүхэлд нь авч хая гэххээд дараа нь тусад нь хураагаад явахаар нэгийг нь дэмжээд нөгөө нь дэмжихгүй нь л бол маш утгагүй, логик утгагүй ийм л юм болчхож байгаа юм. Тэгэхээр энэ дэг дээр өөрчлөлт оруулахгүй бол болохгүй юм байна лээ. Тэгэхдээ маргааш яах вэ, бид нар дахиад өнөөдөр ямар ч байсан Байнгын хороо дээрээ ингээд явчихъя. Тэгээд оруулахдаа хамгийн сүүлд нь тэгээд 1 цохиод үзье. Тэгээд Байнгын хороо хуулийг зөрчихье гэсэн юм гаргаж болох нь уу үгүй юү харъя. 8 дугаар

зүйлийг хэлэлцэж дууслаа. Санал хураалт. Тогтохсүрэн гишүүний горимын саналыг сонслоо. 81,8%-аар санал дэмжигдлээ. 8 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 9 дүгээр зүйл гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсгийн “шалтгаалан” гэснийг “хамааран” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё. Ганболд гишүүн санал хэлье гэж байна. Ганболд гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Ганболд: 9 дүгээр зүйл бол бүхэлдээ энэ зогсоолтой холбоотой асуудал байгаа л даа. Одоо Улаанбаатар хотод бол иргэдийг бас бухимдуулж байгаа зүйл бол энэ зогсоолууд. Төлбөртэй, төлбөргүй, төрийн, хувийн. Тэгээд энийг зүгээр 9.1-ээс нь харах юм болбол нөгөө өмчийн хэлбэрээс үр шалтгаалан зогсоолын төрөл тэдгээрт тавигдах нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтооно гээд. Энэтэй холбоотой зогсоолын төлбөр юм уу зогсоол байлгах эсэх асуудлыг ер нь Нийслэлийн иргэдийн Хурал журам гаргаад шийдээд явах нь гэж ингэж ойлгож байна. Тэгэхээр Нийслэлийн иргэдийн Хурал яг энэ журам гаргаад хувийн зогсоолуудыг төлбөртэй, төлбөргүйг нь шийдээд ингээд явах эрх үүсэх нь л гэж ойлгоод байна л даа энэ заалтаар. Тэгэхээр энийг яг зохицуулах эрх зүйн хувьд иргэдийн Хурал чадах уу. Боломж байгаа юу. Тэгэхээр шууд хуульчлаад явбал ер нь яадаг юм. Иргэдийн Хурал тогтоол гаргаад хувийн хэвилийнхний зогсоолыг төлбөрийн асуудлыг нь шийдээд явна гэдэг бол өөрөө боломжгүй л болов уу гэж хараад байх юм. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт хэлээч.

Н.Энхболд: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Сайнзориг дарга 3 номер.

П.Сайнзориг: Ганболд даргын асуултад хариулъя. Ерөнхийдөө нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэрээс орж хамааран авто зогсоолд тавигдах төрөл, тэдгээрийн стандартыг бол нийслэлийн Иргэдийн Хурлаар зохицуулна. Харин тэр авто зогсоол дээрээс үйлчлүүлсэн хүмүүс ямар хэмжээний төлбөр авах вэ гэдэг асуудлыг нь бол зөвхөн хувийн хэвилийг бол бид зохицуулахгүй. Зөвхөн нийслэлийн эзэмшил буюу нийтийн эдэлбэрийн газар дээр хамаарах энэ авто зогсоолуудынхаа төлбөрийн хэмжээг бид тогтоох юм. Ер нь зүгээр нийслэл дээр өмчийн хэлбэрээс үл хамаарч энэ хувийн болон төрийн буюу орон нутгийн эзэмшилд байгаа энэ зогсоолуудын нэгдсэн менежментийн программ хэмжээг бид хийж байгаа юм. Тодорхой үйлчилгээний байгууллагын гадна ямар зогсоол сул байгаа, тэр дээр машин тавих бололцоотой байна уу, үгүй юү гэдгийг нь төлбөрийн мэдээлэлтэй нь хамт нэгдсэн ийм программ үндэс системийг бас хөгжүүлэлтийн юм явж байгаа юм. Тэгэхээр бид хэд бол хувийн хэвилийн төлбөр мөнгийг тогтоохгүй. Тэнд бол мэдээж өөрсдөө тогтоогоод явна. Зөвхөн орон нутгийн өмчийн авто зогсоолуудын төлбөрийг тогтооно.

Н.Энхболд: Баярлалаа. Дэлгэрсайхан сайд нэмэлт тайлбар хийе гэж байна.

Б.Дэлгэрсайхан: Сайнзоригийн хэлсэн дээр энэ Ганболд гишүүний асууж байгаа зөв л дөө. Хувийн хэвилийнхээ юуг эсвэл хуульчлаад ингээд хамт тогтоохгүй бол тэгээд хувийн хэвилийн зогсоолоос мөнгө авахгүй гээд заачихлаар зэрэг нөгөө бахь байдаг түгжрэл хэвээрээ л байна. Тийм учраас эсвэл Их Хурал дээр хуульчуулж авсан нь дээр эсвэл энэ хувийн хэвшилд олгосон газарт ингээд өмчийн маргаан үүснэ гээд ингээд байгаа юм. Гэтэл хувийн хэвшил маань өөрөө авто зогсоол байгуулна гэж газар аваагүй байхгүй юу. Хотын төвд. Тийм учраас энэ дээрээ бол ялангуяа авто зогсоол дээр бол зам дагасан ялангуяа энэ

карманууд энэ тэрийг бүгдийг нийслэл өөрөө өөртөө өмчийн хэлбэр харгалзахгүй тэр үнэ тарифаа тогтоох, зогсоолын төлбөрөө тогтоох юмыг хийхгүй бол энэ хэзээ ч юу яахгүй шүү Сайнзориг оо. Энэ түгжрэл чинь байхгүй болохгүй. Өмчийн маргаан гарна гээд байгаа. Та хэд энэнээс айх юм байхгүй шүү дээ энэ чинь Нийслэлийн л газар шүү дээ. Зүгээр ашиглуулж байгаа болохоос биш яг юуг нь бол энэ чинь нийслэл өөрөө нутаг дэвсгэрийнхээ юмыг мэдэх ёстой шүү дээ. Би бол ингэж оруулах нь зөв л байх гэж бодож байна. Ямар ч байсан.

Н.Энхболд: Ганболд гишүүн тодруулъя гэж байна. Дараа нь Амараа гишүүн.

Г.Ганболд: Тийм л дээ. Одоо өнөөдөр түгжрэлийн ерөөсөө гол шалтгаан бол ерөөсөө орон сууц ч бай, хувийн сургууль ч бай, цэцэрлэг ч бай тойруулаад хашаа бариад үүдэндээ нэг хаалттай мөнгө авдаг тийм зүйл болгосноос болоод байгаа байхгүй юу. Уг нь нэвт гарах ёстой. Тэр байшин өөрийн эзэмшлийнх гаднах зогсоол бол нийтийн эзэмшлийнх л байх ёстой байхгүй юу. Тийм учраас нэвт нэвт гардаг ийм юм хийх ийм л зохицуулалтыг бид нар ингэж хуульчилж өгөхгүй бол бүгдээрээ ингээд тойруулсан хашаа барьсан нь бол нийслэлийн түгжрэлийн гол шалтгаан шүү дээ. Тойрч явсаар байгаад л нэг хаалгаар л ордог. Хотхон руу ч бай, сургууль руу ч бай, бүх юм руу. Тэгээд энийг л нэвтэрдэг ийм эрх зүйн үндсийг бид нар гаргаж өгч байж л энэ түгжрэлийг чинь гарах нэг шалтгаан байхгүй юу. Нэг юм руу ороход цаашаа нэвт гараад явдаг, эсвэл дотор нь түгжирч, түгжирч буцаж эргэж гардгийг л болиулах ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ дээр заавал нэг бид нар хуулийн нэг юм оруулах ёстой. Тэрнээс зүгээр энэ дээр та нарын оруулж.../минут дуусав/

Н.Энхболд: Баярлалаа. Харин би бол тэр стандарт гэдгийг чинь тэгж

ойлгоод байхгүй. Зогсоол хийнэ гэвэл тэр орчин ямар стандартад нийцсэн байх вэ гэхээр чөлөөтэй нэвтрүүлдэг тэр стандартад нийцсэн байх ёстой. Түүнээс мухарлаад юм уу, хашаатай болгоод энэ тэр гэсэн юмнуудыг нь тэр стандартаараа тогтоогоод явах юм болов уу л гэж ойлгоод л эхний саналыг нь дэмжчихсэн юм. Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Энэ дээр би бас Дэлгэрсайхан гишүүн, Ганболд гишүүн 2-ын хэлж байгаатай бас санал нэг байгаа. Яах вэ, энийг бол бид нар маш тодорхой болгож өгөх ёстой юм. Одоо нийслэлийн хэмжээнд байгаа хувийн ч бай, хувьсгалын ч бай зогсоол нийтийн эзэмшлийн зам талбай дээрх зогсоолыг нийслэлийн иргэдийн ИТХ-аас баталсан журмын дагуу үйл ажиллагааг нь явуулж үнэ төлбөр, тооцоог нь тогтоож хэмжээг нь тогтоож ирсэн. Ийм жишигтэй. 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ зогсоолыг өөрийн замын хөдөлгөөний аюулгүй байдал тэр орчны эрсдэлгүй байдалтай уялдуулсан баталсан стандартаар зохицуулна гэдэг стандартыг бол зөвхөн Улсын Стандарт хэмжил зүйн газар баталж байгаа. Тэр стандартыг баталсан дагуу зогсоолыг байгуулах, ажиллуулах зохицуулалтыг хийнэ гэдэг энэ зүйлээ бид нар хэрвээ хуульчлах гэж байгаа бол тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Уг нь бол энийг хуульчлах шаардлагагүй юм байгаа юм. Энэ хуулийн энэ 9 дүгээр заалт бол үндсэндээ ИТХ-ын журмын заалтууд орчихсон байгаа байхгүй юу. Яг энэ зайлиггүй хэрэгжих шаардлагатай, энэ гарцаагүй байх ёстой гэдэг ийм заалт ерөөсөө энд огт байхгүй байгаа юм. Тэгээд би түрүүн хэлээд байгаа юм. Нийслэл ч бай, аймаг ч бай энэ бие даасан орон нутгийн эрх барих дээд байгууллага өөрөө удирдах байгууллагын эрх хэм хэмжээг бид нар бодолцохгүй бол энийг бүгдийг нь Улсын Их Хурал дээр утаа ч байсан татаж авдаг, түгжрэл ч байсан хуульчилдаг, орон сууц барьсан ч хуульчилдаг, орц,

гарц байсан ч хуульчилдаг, цаашилаад газар хурааж авсан ч хуульчилдаг ийм байдлаар явах юм бол бид энэ аймаг, Нийслэлийн ИТХ ч гэж байгаад хэрэггүй, бие даасан бүтэц гэж байгаад ч хэрэггүй. Сүүлийн үед бол ер нь Улсын Их Хурал, Засгийн газаргүй юм байхгүй боллоо шүү дээ. Энэ заалтаа бол нэг мөр хасаж, татаж аваад тэр дүрэм, журмаараа зохицуулах асуудал дээрээ анхаарахгүй бол цаашидаа ер нь ийм байдлаар бид энэ хот, орон нутаг, Засгийн газар, төрийн төлөөллийн зарчмыг хэрэгжүүлж явна гэх юм бол ер нь бол их л зарчим алдагдаж байна даа. Энэ улс чинь уг нь явж ирсэн хууль цаазын уламжлалтай, төрт ёсны зарчимтай, дүрэм, журамтай. Тэгээд бүх зүйлээ эх толгойгүй ингэж хольж хаяад эргээд тэгээд Их Хурал, Засгийн газар нь ч зохицуулж чадахгүй, иргэдийн Хурал, нийслэл, аймаг нь ч зохицуулж чадахгүй эзэнгүй болоод ингээд дуусах ийм юм руу олон хуулийн заалтууд, олон хуулиуд явж байгаа шүү. Энийгээ оруулж ирж байгаа нөхөд та хэд маань сайн анхаараарай. Наад хотын аймаг, орон нутгийн онцлогийг өөрсдөө сайн бас судалж ойлгоцгоогоорой. Энэ бол их тийм явцгүй бөгөөд их хуумгай л юмнууд яваад байгаа шүү. Ялангуяа энэ хууль бол.

Н.Энхболд: Санал хэллээ. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Амараа дарга аа, энэ ийм юм байгаа юм. Зүгээр яах вэ, энэ хуулийг хийснээрээ юуг зохицуулах гээд байгаа юм бэ гэхээр ер нь бол түгжрэлийг бууруулах, бас орон сууцжуулах асуудлыг нэгдсэн бас стандарттай болгох нэг ийм олон хуулиудад бас давхардаж байгаа юм байгаа. Тэрийг ойлгож байгаа. Тэгэхдээ энэ хуулийн ач холбогдол нь бол тэр шүү. Тэгэхээр би бас энэ ажлын хэсгийнхэндээ нэмж хэлэх юм бол юу гэхээр нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэрээс үл хамааран авто зогсоолын төрөл, тэдгээрт тавигдах нийтлэг шаардлага,

тэгээд энэ стандарт гэдгийг нь аваад төлбөрийг тогтооно гэдэг, нийслэл өөрөө тогтооно гээд ингээд оруулчихсан нь бараг шулуухан. Тэгэхгүй ингээд би түрүүн дахин хэллээ шүү дээ. Жишээлбэл, Теди төв ч бай хувийн зогсоол гээд байгаа юм. Тэгтэл зам дагасан зогсоол байхгүй юу хамгийн гол нь. Энийг Нийслэл өөртөө л авахгүй юм бол тэнд нэг лангууны хэдэн хүмүүс өдөржин машинаа тавиад л ямар ч үйлчлүүлэгч орох зай байхгүй. 1 дүгээрт энийг бодох хэрэгтэй байгаа юм

2 дугаарт энэ эмнэлгүүдийн асуудал байгаа юм. Бүх төрийн эмнэлгийн ажилчид хаашаага дүүргэхдээ байгаа байхгүй юу. Тэгээд энийг нэг мөсөн л Нийслэлийн иргэдийн Хурал нь төлбөрөө тогтооно. Энийг нийслэл бол өмчийн хэлбэр харгалзахгүй бүх зогсоолуудыг өөрийнхөө юунд авна хяналтдаа авна л гэсэн ийм л юмыг л оруулчихмаар санагдаж байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Гишүүд асуулт асууж, саналаа хэлж дууслаа. Стандартын тухай асуудлыг түрүүн би хэлсэн. Энэ стандартаар нэлээн зүйлүүд зохицуулагдах байх. Ингээд бичгээр ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас ажлын хэсгийн саналаар 9.1, 9.5 дахь хэсгийн “шалтгаалан” гэснийг “хамааран” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг хасах гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ бол яг саяын яриад байгаа юмнуудтай ерөнхийдөө нийцээд байгаа заалт юм байна лээ л дээ. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал бүлгийн нэр өөрчлөх тухай, Гарчгийг хасах тухай.

Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ” “НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ” гэсэн гарчгийг хасах. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

10 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа. Дахиад 1 байгаа юм байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах. Асуулт Ганболд гишүүн.

Г.Ганболд: 10 дугаар зүйл дээр яах вэ, 10.5-ыг хасахыг нь бол дэмжиж байна. Энэ бол боломжгүй заалт. 10.6 Нийслэл хот нийтийн тээврийг хөгжүүлэх сантай байна гээд. Сантай байна гэж байна шүү дээ. Юунаас бүрдэхийг нь зааж өгөөч. Энэ сангийн эх үүсвэр нь юу юм.

Үгүй ээ, нийслэл хот нийтийн тээвэр хөгжүүлэх сантай байна гэж байна шүү дээ. Тэгээд эх үүсвэр.

Н.Энхболд: 13 дугаар зүйл дээр эх үүсвэрүүдийн тухай биччихсэн байгаа юм байна.

Г.Ганболд: Тийм байна. За уучлаарай.

Н.Энхболд: Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Гишүүдээ дуудахгүй бол энэ чинь нэг л юм болоод байна шүү. 10 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

11 дүгээр зүйл. Бичгээр ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал гишүүдээс байхгүй. Ажлын хэсгээс байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Автотээврийн тухай хуулийн 15.1 дэх хэсэг,” гэснийг хасах. Санал хураалт 54,5 хувиар санал дэмжигдэж байна.

11 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа. 12 дугаар зүйл. 12 дугаар зүйл дээр гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс санал байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “авто замын даацыг” гэснийг “тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг” гэж өөрчилж, мөн хуулийн 12.2 дахь хэсгийн “тээврийн хэрэгслийн” гэсний өмнө “тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан” гэж нэмэх. Ажлын хэсгийн гаргасан санал. Санал хураалт. Ганболд гишүүн асуулт.

Г.Ганболд: Энэ бол нийслэлийн улсын бүртгэлийн нөгөө автомашины дугаарт хязгаарлалт тогтоох заалт байна л даа. Тэгээд энэ ямар нэгэн одоо тийм юу байхгүй юм уу. Өөрсдөө үзэмжээрээ нэмэгдлээ гэх юм уу, хэдэн хувь гэх юм уу, эсвэл зүгээр тоо нь өсчихлөө гэх юм бол мөнхийн өсөлттэй л дөө. Тодорхой хувь тогтоож хязгаарлах юм байхгүй бол энэ чинь үзэмжийн юм болно шүү дээ. Мөнхийн л өсөлттэй. Тэгээд ингэснээрээ бол машин авахгүй байна гэсэн ойлголт биш шүү дээ. Хөдөө орон нутагт, аль нэг аймаг дээр очоод л дугаар авна шүү дээ. Тэгээд л тэр дугаараараа энд л явна. Энэ бол зүгээр яах вэ аргын хувьд бол яг нарийндаа бол шийдэл бол биш л дээ. Тэгэхээр яах юм. Хэдэн хувь өсвөл гэж хувь хувь тогтоохгүй юм уу. Тэгээд л одоо орон нутгаас дугаар аваад, тэр дугаараараа хотод л оролцоно шүү дээ.

Н.Энхболд: Дэлгэрсайхан гишүүн хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Ганболд гишүүн ээ, энэ ийм учиртай юм. Энэ Улаанбаатар хот тээврийн хэрэгслийн дугаар олгохыгоо өөр дээрээ авъя гээд байгаа нь 1 дүгээрт аль болохоор тээврийн хэрэгслийг нэмэгдүүлэхгүй байх хамгийн гол бодлого энэ байгаа юм. Номер олгохгүй байвал, тэгэхдээ номер олгох юм бий. 1 дүгээрт бусад өндөр хөгжилтэй улс орнуудын жишгээр 1 дүгээрт номероо өндөр үнээр худалдах юм уу, тэрийг бол иргэдийн хурал нэг журам гаргах ёстой. Худалдах юм уу

эсвэл машинаа хөдөө зараад юм уу, эсвэл машинаа устгаад тэр номероороо машин авч болно. Ингэж хязгаарлах гэсэн санаа юм байгаа юм. Таны хэлдэг тэр хөдөөгийн дугаар авч орж ирнэ шүү дээ гэдэг чинь зөв. Тэгэхдээ бид энэ хуулиар бол хөдөөгийн дугаартай машинуудыг хотын төв рүү орж ирэхдээ эхний 24 цаг үнэгүй, дараагийнх нь ингээд төлбөр явах юм. Тэр төлбөрт орохгүй гэвэл орж ирэх гарц дээр нь үнэ төлбөргүй зогсоолууд хийж өгөөд аймгуудын орж ирэх тэгээд тэндээсээ автобусаар орж ирж болно, эсвэл өөрөө машинтайгаа орж ирээд төлбөрөө төлөөд явж болно гэдэг ийм заалт байгаа юм. Тийм учраас аль болохоор л энэ тээврийн хэрэгсэл чинь зам дээрээ багтахгүй байгаа учраас л арга буюу ийм юм хийж байгаа юм аа. Тэгэхгүй бол АТҮТ дээр замбараагүй олголт явагдчихаад байгаа байхгүй юу. Ер нь аль ч хотод хотынхоо дугаарыг өөрсдөө олгодог ийм жишиг л байгаа юм. Төлбөрөө төлөөд явах юм хот дотор. Тэгээд жоохон хязгаарлая л гэж байгаа юм.

Н.Энхболд: Баярлалаа.
Амарсайхан гишүүн асууя.

С.Амарсайхан: 12 дугаар зүйл дээр саяын ярьсан асуудал яах вэ, хязгаарлалт тогтоох зохицуулалт байх ёстой. Тэгээд л би дахиад л нөгөө сэдэв рүүгээ орох гээд байгаа юм. 1 дүгээрт энэ авто тээврийн хэрэгслийн тухай хуулийн 17 дугаар зүйл дээр байж байгаа юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зохицуулалт, хязгаарлалтыг тогтооно гээд Замын хөдөлгөөний авто тээврийн хэрэгслийн тухай хуулиараа зохицуулчихсан. Энэ хуулиа бариад НИТХ, НЗД өөрсдөө бүрэн эрхийнхээ хүрээнд өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуульд заасан тэр нутаг дэвсгэр дээрх нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бүрэн эрхтэй гэсэн тэр заалтаа үндэслээд, ингээд энэ зохицуулалтаа хийчих боломжтой байхгүй юу. Тэгээд одоо яах юм. Энэ

хуулиар тэгээд бусад аймаг, орон нутгуудад бас адилхан үйлчлэх юм уу. Энэ юу гэж ойлгох вэ гэдэг асуудал чинь өөрөө эргэлзээтэй. Нийслэл дээр тэгээд зохицуулчихдаг юм байна. Гэтэл бусад аймаг, орон нутаг дээр яаж зохицуулах юм. Ямар зохицуулалтууд явах юм.

Нөгөө талаараа миний хэлээд байгаа зүйл бол уг нь Иргэдийн хурал, Засаг даргын өөрсдийнх нь бүрэн эрхийг нь л та нар эрхээ авч үлдээч ээ л гэж, бүрэн эрх нь байгаа зүйлүүдээ ингээд детальчлаад, журамлаад, хууль нэрээр ингээд бүр хэсэгчилж, махчилж оруулж ирээд, явж явж өөрсдийн чинь дараа дараагийн арга хэмжээ хэрэгжүүлэх эрхийг чинь хязгаарлалт болж явна. Нөгөө нутгийн өөрөө удирдах ёс гэдэг юм чинь байхгүй болно. Тэгээд энэ жишжиг сажиг хуулиуддаа цаг үеийн нөхцөл байдлыг шийдэх гэсэн нэг удаагийн шинж чанартай шахуу ийм хуулиуддаа та нар өөрсдөө хөтлөгдөж дөрлөгдөөд дараа дараагийн асуудлуудаа бие дааж шийдэх орон нутгийн өөрийнх нь чадавх байхгүй болно шүү. Энийгээ та нар өөрсдөө сайн харж энэ хуулиа батлуулах талаас нь анхаараарай.

Н.Энхболд: Санал хэлсэн юм байна. Саяынхаа томъёоллоор даацыг гэснийг л арай дэлгэрэнгүй болгоод сүлжээний нятрал, түгжэрэл, өсөлт энэ юмнуудтайгаа уяаж байгаа юм байна. Санал хураалт. 7 гишүүн дэмжиж 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Би нөгөө Төрийн байгуулалтын байнгын хороонд байдаггүй юм. Тэгэхдээ би нэг товчхон нэг санал хэлчээд гарах гэсэн юм. Дундуур нь орчихлоо. Энэ ажлын хэсэгт намайг оруулсан юм. Тэгээд яг энэ ажлын хэсэг хэд хэд хуралдах үед би нөгөө цагаатгалын комиссын ажлаар хөдөө болон гадаадад томилолттой хугацаа яг

таараад 1 ч удаа энэ энэ сууж чадаагүй юм. Тэгэхээр энэ нөгөө чуулган дээр унидаг ажлын хэсгийн гишүүдийн нэрс гээд унидаг шүү дээ. Тэрнээс намайг хасаж өгнө үү гэж Байнгын хороон даргад хүсэж байгаа юм. Угаасаа би ажлын хэсэг, энэ хуулийн юуг нь бас нарийн сайн мэдэхгүй байгаа юм. Тийм учраас энэ юунаас намайг хасаж өгнө үү. Баярлалаа.

Н.Энхболд: Саналыг сонслоо тэгээд дэгээ харж байгаад явчихвал болох байх. Тэгээд санал хураалт 12.3 дахь хэсгийг хасъя. Тэр саналыг нь санал, дүгнэлт дээрээ биччихье. 72,7%-аар санал дэмжигдлээ. 12 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

13 дугаар зүйл гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс байна.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “авто зогсоолыг” гэснийг “автобусны буудал, авто зогсоолыг” гэж, 13.1.3, 13.1.4, 13.5.1, 13.5.4 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “нийтийн” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.5.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тийм байна. Энэ автобусны буудал, авто зогсоолыг гэж засаж уншлаа. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 13 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

Төслийн 14 дүгээр зүйл дээр гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс байна. Эхлээд би саналаа уншиж байна. Тийм ажлын хэсгээс ирүүлсэн санал.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчлөх гэсэн ийм санал ирсэн байна. Мөнхцэцэг гишүүн. Мөнхцэцэг гишүүн, дараа нь Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ газар чөлөөлөлтийн асуудал бол их чухал асуудал. Тэгэхдээ үүний цаана о нөгөө хүний эрхийн нэлээн асуудлууд гараад байдаг. Жишээлбэл 2018 онд Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улсдаа хүний эрхийн 17 дугаар илтгэлтэй тухайн үед дахин төлөвлөлт гэдэг нэрээр явж байсан газар чөлөөлөлтөд өртсөн, тэгээд газраа чөлөөлөөд орон байргүй хоцорсон иргэдийн тухай нэлээн бас том дүгнэлтүүдийг өгөөд, Улсын Их Хурал дээр бас хэлэлцүүлэхээр явуулж байсан. Тухайн үед бол яг энэ газар төлж чөлөөлөлтөд өртөөд, газраа өгчихсөн иргэд маань нэлээд олон жил нөгөө нөхөн олговор аваагүй, газрыг нь орон сууцаар солино гэсэн тэрийгээ аваагүй...

Н.Энхболд: Мөнхцэцэг гишүүнийх яагаад тасарчхав.

Ц.Мөнхцэцэг: Тэгээд тухайн үед бол нэлээд олон иргэд хохирсон, зарим нь бараг өнөөдөр хүртэл энэ газар чөлөөлөлтөөс улбаатай хохирлоо барагдуулж чадаагүй байсан юм. Тэгээд Хүний эрхийн Үндэсний Комисс, Олон улсын Эмнести Интернэшнл байгууллагууд нэлээд олон зөвлөмж өгсөн. Газар чөлөөлөлт бол яг энэ орон сууцтай байх хүний суурь эрхийг хангаж байгаа асуудал учраас энэ дээр бол хууль эрх зүйн зохицуулалт маш сайн байх ёстой. Тухайн чөлөөлөлтөд орж байгаа иргэдийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг үндэслэх гээд. Тэгээд манай энэ хуулийн төсөл дээр бол бас тодорхой дэвшилттэй заалтууд ороод, нөхөн олговрыг хэд хэдэн хувилбараар өгөхөөр бол явсан байна. Чөлөөлөлтөд өртөж байгаа иргэдийн 70 орчим хувийн саналыг авна гэсэн ийм дэвшилттэй заалтууд байна. Тэгэхдээ яг энэ 14.7 дээр нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмыг Засгийн газар батална гээд. Өөрөөр хэлбэл нөгөө газар чөлөөлөлтөөс улбаатайгаар нь орон байраа гэдэг юм уу, эсвэл тодорхой мөнгөн хэлбэрийн нөхөн олговор хэрхэн авах тухай ийм тодорхой зохицуулалтыг

зөвхөн журмаар оруулахаар ингээд хаячхаж байна. Энэ бол учир дутагдалтай. Жишээлбэл, тухайн газраа өгчхөөд хэдий хугацааны дараа, эсвэл хэдий хугацааны дотор энэ нөхөн олговроо олж авах юм. Энийг нь төрийн аль байгууллага хариуцах юм гэсэн ийм нарийн зохицуулалт хэрэгтэй байна. Тэр өмнөх бид нарын алдаа бол тэр 2018, 2015, 2016 онд бол ерөөсөө тухайн хувийн компанитайгаа тооцоо хийж, иргэн өөрөө хөөцөлдөж олж авна гээд асар олон иргэдийн эрх бол зөрчигдсөн байсан. Тэгэхээр одоо энэ 14.7-оо улам баяжуулаад ер нь энэ нийгмийн суурь хэрэгцээ, тухайн хүний амьдрах орон байр гэдэг бол гол хэрэгцээ учраас энийг журмаар биш хуульдаа оруулаад өгөх боломж байхгүй юу гэдгийг ажлын хэсгээс ер нь асуумаар байна. Тэгээд хохирлыг хэрхэн барагдуулах вэ, нөхөн төлбөрийг хэдий хугацааны дотор өгөх юм гэх мэтийн тодорхой хариуцлагын механизм орохгүй бол дахиад тэр нөгөө орон байргүй болсон иргэдийн кэйсүүд маань давтагдах вий гэсэн ийм болгоомжлол байна. Үүнийг хүний эрхийн дэд хорооны даргын хувьд бас хэлж байгаа юм. Тэгэхээр ажлын хэсгээс тодорхой хариултаа авъя.

Н.Энхболд: Баярлалаа. Эхлээд энэ 65-ыг 70 болгосноо хураачихъя. Тэгээд тэрний дараагийн заалт нь байгаа шүү дээ. Тэгвэл Сайнзориг хариул. 3 номер.

П.Сайнзориг: Мөнхцэцэг гишүүний асуултад хариуль. Өмнөх явж ирсэн практикууд бол энэ газар чөлөөлөлтийн асуудал манай дээр ерөнхийдөө хууль, эрх зүйн тодорхойгүй орчинтой. Өөрөөр хэлэх юм бол түрүүн бас хуулиар эрх олгогдоогүйгээр хүний өмчид халддаг байдал манайд орон нутгийн шийдвэрүүдээр маш их байсан. Энэ нь өөрөө эргээд Үндсэн хуулийн цэц болон захиргааны шүүх дээр унадаг учраас аливаа төсөл хөтөлбөрүүд үндсэндээ амжилтгүй зогсдог ийм талтай яваад байгаа. Тэгэхээр энийг л бид хэд өөрчилж бас тодорхой орон

нутаг бас хууль тогтоогч бас эрхээ авсны үндсэн дээр бас дүрэм, журам гаргаж байж тодорхой харилцааг зохицуулъя гэдэг ийм зүйл бол байгаад байгаа. Өмнө нь Бат-Үүл даргын үеэс улбаатайгаар яг ИТХ-аар баталсан журам бол Цэц дээр асуудал үүссэн. Үүнтэй холбоотойгоор маш олон иргэд хохирсон ийм нөхцөл байдлууд байгаа гэж бас хэлдэг. Дараа нь гэр хорооллыг дахин төлөвлөх энэ асуудал хууль эрх зүйн хүрээнд орж ирсэн. Гэхдээ энийг нь хувийн хэвшлийн компани өөрсдөө яг иргэн буюу тэр нөлөөллийн бүсэд өртөж байгаа этгээдтэйгээ харилцаад яв гэдэг зүйлээр хаячихаар, төр оролцоогүй явчихаар үндсэндээ нөгөө цөөхөн хэдэн айл нь үр шимийг нь хүртдэг ч юм уу олон айлууд бас хохирдог ийм тохиолдлууд байгаа. Мэдээж амжилттай явсан цөөн тооны төслүүд бол байна. Энийг бас үгүйсгэж ерөөсөө болохгүй. Гэтэл бас нэлээдгүй олон айлууд хохирдог ийм жишээнүүд одоо ч гэсэн нийслэл дээр гомдол ирдэг ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр бид хэд энэ дээр ямар ч байсан суурь зохицуулалтууд буюу ямар хэмжээний нөхөн олговор олгох юм, ямар хэлбэртэй байх юм, хэн шийдвэрийг нь гаргах юм, маргааныг нь яаж шийдвэрлэх юм гэдэг зүйлүүд байгаа. Харин зүгээр процессын хэм хэмжээ буюу тэр ямар цаг хугацаа гэдэг юм уу тодорхой процессчилсон юмнуудыг нь Засгийн газрын баталсан журмаар тогтооё гэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ өөрөө Засгийн газрын шийдвэр маань Захиргааны ерөнхий хууль болон Үндсэн хуулийн цэцээр хянагддаг. Парламент бас Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа учраас бас илүү их хүний эрхийг хангасан ийм журмууд бол батлагдана гэдэг зүйл байгаа. Тэгэхээр энэ зүйл рүүгээ бид хэд бас чиглүүлж энийг бас харж байгаа гэдгийг хэлье. Тэгээд мэдээж хууль зүйн техникийн хувьд бас боломжтой байдлаараа хууль дээр тусгах бололцоотой. Тэр болгон процессын хэмжээнүүдийг бас хууль дээр тусгахаар уян хатан байх ч гэдэг юм уу, эргээд бас

нөхцөл байдалдаа тааруулж бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орохоос эхлээд хүндрэлүүд зүгээр байдаг. Тэгэхдээ таны хэлж байгаа суурь яг иргэдийн өмчлөх эрхтэй холбоотой ийм зохицуулалтууд бол аль болохоор бид нар хууль дээр тусгасан гэж хэлж болно.

Н.Энхболд: Мөнх-Оргил гишүүн асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би энэ 4 дүгээр бүлгийг буюу нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх, гэр хорооллыг орон сууцжуулж, барилгажуулах гэдэг энэ бүлгийг би бүхэлд нь дэмжихгүй байгаа юм. Олон удаа хэлж байгаа. Тэгэхдээ ажлын хэсэг дээр бол санал хураалгаагүй. 3 үндэслэл байгаа юм.

1 дүгээрт байна шүү дээ. Энэ 65-ыг 70 болгосноор бид нар ямар ч үр дүнд хүрэхгүй. Одоо 65 байхад бид нар газар чөлөөлж чадахгүй байгаа байхгүй юу. Тэрбум тэрбумаар нэхээд л, тэгээд л энэ асуудал бүтэн гацаад л орон сууцжуулах ажил явахгүй байна. Тэгэхээр энэ бол бүтэхгүй. 65 байсан ч бүтэхгүй, 70 болгоод бүр бүтэхгүй.

2 дугаарт Үндсэн хуульд энэ хүний өмчийг чинь хуулиар л хурааж авна гэж байгаа шүү дээ. Хүний өмчид хуулиар халдана гэж байгаа юм. Гэтэл ерөөсөө гол халдах газар чөлөөлөх журмыг Засгийн газар батална гэххэж байгаа байхгүй юу. Сая Мөнхцэцэг гишүүний яриад байгаа. Тэгээд энийг чинь Засгийн газар батлах юм биш ээ. Энийг Улсын Их Хурал хуульжуулж оруулах ёстой байхгүй юу. Тэр яриад байгаа процессыг нь, үнэлгээг нь, давж заалдах үнэлгээтэй нь санал нийлэхгүй бол яаж давж заалдах юм, давж заалдсан шийдвэрийг нь яаж хэрэгжүүлэх юм, юу юунд зориулж авах юм гээд энэ чинь маш олон асуудлууд байгаа байхгүй юу. Энийгээ заавал хууль болго гээд Азийн хөгжлийн банкнаас төсөл гаргаад энэ чинь олон жил ажиллаад, Азийн хөгжлийн банк 30,

40 хуудас хууль, тэгээд тэрийг дагаж гарах журмуудтай нь бэлдээд Засгийн газарт өгчихсөн юм шүү дээ. Тэрийгээ л өргөн барьчих гээд байхад л ингээд тусад нь шал өөр юм болгоод оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол өмчлөх эрхтэй шууд холбоотой асуудал.

3 дугаарт орон сууцжуулахын тулд газар чөлөөлөх асуудлыг нийтийн зайлиггүй хэрэгцээнд газар дайчлан хурааж авах асуудалтай холиод байгаа юм. Энэ чинь тусдаа байгаа байхгүй юу. Үндсэн хуульд ингэчихсэн байгаа байхгүй юу. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө гэж. Энэ чинь юу гэж хэлээд байгаа юм бэ гэхлээр орон сууцжуулах төслүүд биш байхгүй юу. Нийгмийн зайлиггүй хэрэгцээ гэдэг чинь үндсэн магистраль төмөр зам барих гэж байна, эсвэл өндөр хүчлийн шугам татах гэж байна, эсвэл үерийн далан байгуулах гэж байна. Нийт эрх ашиг, нийтийн эрх ашиг тэр зөвхөн тэнд сууж байгаа хэдэн хүмүүсийн асуудал биш. Ийм юманд улс шууд дайчилж авна. Тэнд 60 хувь зөвшөөрөх үү, 10 хувь зөвшөөрөх үү, 100 хувь зөвшөөрөх үү асуудал байхгүй шүү дээ. Одоо юу гэх юм, энд далан барих хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ хүмүүс амь нас эрстэх гээд байна гэхээр 10 хувь нь зөвшөөрчихсөн, 90 хувь нь зөвшөөрөхгүй бол тэгээд далан барихгүй юм уу. Эсвэл Улаанбаатар хотын 1,5 сая хүний хэрэгцээнд гарцаагүй шаардлагатай байгаа төмөр зам юм уу, метро барих гэхлээр 30 хувь нь зөвшөөрчхөөд, 40 хувь нь зөвшөөрчхөөд 60 хувь нь зөвшөөрөхгүй гэвэл тэрийг дайчилж авч чадахгүй болчихоод байна шүү дээ. Ингээд 2, 3 тусдаа асуудал байгаа байхгүй юу. Тэгээд бүгдийг нь хольж хутгаж орж ирчхээд, одоо үүгээрээ явах юм бол бид нар ерөөсөө хэзээ ч газар чөлөөлүүлж чадахгүй. Энийг Байнгын хороо, манай Улаанбаатар хот, хотын удирдлага, энэ асуудал хариуцсан сайд нар анхаарна биз

дээ. Би энэ саналыг бол дэмжиж чадахгүй байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Саналууд хэлчихлээ. Хариултаа авчихлаа. 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчлөх. Санал хураая. Асуулт асуулаа, саналаа ярилаа. Шаардлага байвал гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Юу ч гэсэн энийгээ хураачихъя. Тэгээд саналтай гишүүд байвал дараа нь зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Санал хураалт. 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчилъе. Санал хураалт. Хүлээж байгаарай Амараа сайд аа, түр хүлээгээрэй. Санал хураалаа. Ажлын хэсгийн санал үлдлээ. Уналаа 65-аараа үлдлээ. Энэ дээр саналтай хүмүүс байна уу 65-аар нь үлдэж байгаа юм байна. Энэ санал уначихлаа.

Чуулганаар орно. Тэр дээр илүү их л асуудал болох байх даа. Цаашаа явах уу. Манай байнгын хороо уг нь жаахан ч гэсэн цааш нь ахиулбал дээр байсан юм даа. Одоо дууслаа. Өөр санал гаргах хүн байхгүй. 15 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. 16 дугаар зүйл дээр гишүүдээс ирсэн санал алга байна. Ажлын хэсгээс санал ирсэн.

Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“16.4.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 16.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол уг хугацаа дууссанаас хойш 14 хоногт багтаан үнэлгээ хийлгэнэ.” Санал хураалт. Саяын санал 74,7 хувиар дэмжигдлээ.

Түрүүн нэг зүйлийг орхиод уншсан байна. 15 дугаар зүйл дээр гишүүдээс болоод ажлын хэсгээс санал байхгүй. 15 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Сая 16-аас санал хураалцсан. Одоо 17 дугаар зүйл. Гишүүдээс санал байхгүй. Ажлын хэсгээс байна.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “байриил буюу дэд төвийг түшиглэн” гэснийг “дэд төвийн байриилд” гэж өөрчлөх. Ганболд гишүүн ээ, Ганбаа гишүүн ээ саналаа хураая. Санал хураалт. 17 дугаар зүйл дээр санал хураалт явж байна. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 16 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

19 дүгээр санал. Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь хэсгийн “байриил буюу дэд төвийг түшиглэн” гэснийг “дэд төвийн байриилд” гэж өөрчлөх. Санал хураалт. Саяын санал 72.7-гоор дэмжигдчихлээ. Амараа сайд саналаа хэлчих дээ. Сонсоодохъё. Найруулгаар авч болох нь уу, үгүй юу.

С.Амарсайхан: Энэ дээр зүгээр энэ дэд төвийн байриилд гэхихсэн байгаа байхгүй юу. Гэтэл одоо дэд төвийн байриил гэдэг чинь манай нийслэлд уг нь бол 7 билүү 14 дэд байриилтай. Тэрнээс одоо байгаа нь Баянхошуу, Сэлбэ. Тэгэхээр энэ дээр дэд төв болон бусад байриилд гэж “бусад” гэдэг үгийг нэмж өгөхгүй бол зөвхөн дэд төвд орон сууцны хөтөлбөр хэрэгжих юм шиг ийм хязгаарлагдмал заалт яваад байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Ийм байна шүү дээ. Одоохон. Энэ чинь яг анх орж ирсэн томъёолол нь бол байна шүү дээ ингэж байгаа юм. Хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байриил буюу дэд төв нэг юм яриад байгаа байхгүй юу. Тэгж ойлгоод ажлын хэсэг найруулгын хувьд залруулаад дэд төвийн байриилд гэж оруулж ирсэн гэж бодож байна. Амараа сайд аа, энэ нөгөө анх орж ирсэн хувилбар дээрээ ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байриил буюу дэд төв гээд энэ нэг юм яриад байгаа байхгүй юу. Тэрийг нь би найруулгын хувьд засаад л

дэд төвийн байршилд гэж оруулсан юм байна. Анхнаасаа дэд төвийн байршилд гэсэн санаа байсан юм байна л гэж л ойлгоод санал хураагдчихлаа шүү дээ. Зөв үү ажлын хэсэг. Бусад юм өөр заалтуудаараа байгаа байлгүй дээ. 17 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

18 дугаар зүйлийг хэлэлцье. Гишүүдээс болон ажлын хэсгээс ирсэн санал байхгүй. Зүйлийг хэлэлцэж дууслаа.

19 дүгээр зүйлийг хэлэлцье. Гишүүдээс санал алга байна. Ажлын хэсгээс байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “барилгажилтын төслийг” гэснийг “хот байгуулалтын холбогдох баримт бичгийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “гэрээ байгуулах” гэсний дараа “төслийн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 19.1.5 дахь заалтын “талбарыг” гэсний өмнө “нэгж” гэж тус тус нэмэх. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.7 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн санал хураалт. Та нар ярьж байгаад санал хураалтаас хоцорчхоод, тэгээд дараа нь юм яриад байв. Олон гэдэг үгийг нь хасчихъя. 63,6%-аар санал дэмжигдлээ. 19 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

20 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Гишүүдээс ирсэн санал байхгүй байна.

Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.4, 20.1.5 дахь заалт тус тус нэмэх:

“20.1.4.холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг нэгдсэн удирдлагаар хангах;

20.1.5.төр, хувийн хэвшлийн түншилэл, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.” Ажлын хэсгийн санал. Санал хураалт 54,5 хувиар санал дэмжигдэж байна. Мөнхцэцэг гишүүнийхийг дэмжсэнд аваарай. 20 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

21 дүгээр зүйлийг хэлэлцье. Гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс байна.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “нийслэлийн авто замын даацыг харгалзан” гэснийг хасах. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 21 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

22 дугаар зүйл дээр гишүүдээс ирүүлсэн санал байхгүй. Ажлын хэсгээс санал ирсэн байгаа.

Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Ерөнхий архитекторын чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” Ажлын хэсгийн санал. Санал хураалт 72,7 хувиар санал дэмжигдэж байна. Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэсэн үг байгаа. Төрийн бус байгууллага гэсэн үг байхгүй шүү. 22 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

23 дугаар зүйлийг хэлэлцье. Гишүүдээс ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс гишүүд, Байнгын хороодоос ирсэн санал байхгүй. Түрүүн бүх газрууд тэгж явах ёстой шүү.

Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтын “байдал, замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын” гэснийг “байдлын” гэж

өөрчилж, мөн зүйлийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. Байнгын хороо энэ хүмүүст зөв ижилхэн материал тараасан юм байгаа биз дээ. Энэ яагаад гишүүдийн зүгээс гомдол гараад байна. 63,6 хувиар энэ санал дэмжигдлээ. 23 дугаар зүйлээр санал хурааж дууслаа. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Энэ дээр нэг зүйл тодруулах гэсэн юм. Түрүүн 14 дүгээр санал буюу төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн авто замын даацыг гэснийг тээврийн хэрэгслийн өсөлт авто замын сүлжээний нягтрал замын хөдөлгөөний түгжрэлийг гэж өөрчилж мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн тээврийн хэрэгслийн гэсний өмнө тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан гээд 12.1 дээр хязгаарлалт тогтооно гэдэг дээр Нийслэлийн Засаг дарга хязгаарлалт тогтооно гээд санал хураасан шүү дээ. Тэгээд 21.1.3 чинь бас яг нийслэлийн авто замын даацыг харгалзан нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг Нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн дахиад тогтооно гээд ороод ирж байгаа байхгүй юу. Давхцахгүй юу л гэдэг санаагаар асууж байгаа юм. Нийслэлийн авто замын даацыг харгалзан гэдгийг нь хасаад л яг Засаг дарга тогтооно гэдэг юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр зүйл, заалт давхцахгүй юу л гэж асууж байгаа юм.

Н.Энхболд: Хэн хариулах вэ. Сайнаа дарга хариулах уу. Ажлын хэсгийн гишүүн, асуудал хариуцсан сайд давхцахгүй гэж хариулт өглөө. Протоколд тусгаарай. 23 дугаар зүйлийг хэлэлцээд дууслаа.

24 дүгээр зүйл. Гишүүдээс болон бусад Байнгын хороодоос ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс байна.

Төслийн 24 дүгээр зүйлийг хасах санал ирүүлсэн байна. Санал хураалт. Тогтохсүрэн гишүүн асуулт.

Д.Тогтохсүрэн: Үгүй ээ, энэ 24 дүгээр зүйл уг нь их хэрэгтэй юм байгаа юм. Түгжрэлийг чинь өнөөдөр бол хүмүүс харахаар нэг хэдэн дарга нар бий болгочихсон юм шиг л хараад байгаа байхгүй юу. Яг амьдрал дээр бол энэ нийслэлийн иргэд л бид замбараагүй байдлаасаа болоод л өнөөдөр ийм байдалд орчихсон байхгүй юу. Тэгээд иргэн, аж ахуйн нэгж үүргээ тэгээд аваад хаячихаар чинь энэ чинь одоо юу гэсэн үг юм. Би одоо тэгээд шуудхан хэлэхэд хамгийн их хүндрэл учруулж байгаа нөхдүүдийн нэг нь аж ахуйн нэгжүүд. Барилга барьж байгаа аж ахуйн нэгжүүд яадаг вэ. Бариад л нэг аймаар том төмрийн юм уу, бетонон хашаа хийдэг. Бүх замыг хаадаг, гарцгүй болгодог. Энэ Хан-Уул дүүрэг бол тэр чигээрээ бетонон хашаагаар эргэн тойрон зам явж чадахгүй тэгээд зам нь тойрч явсаар байгаад таарч байгаа шүү дээ. Тэгээд нөгөө иргэн, аж ахуйн нэгжийн үүрэг хамгийн гол юмыг нь хасаад хаячхаж байх юм. Харин энийг тодруулж, нарийсгаж иргэн, аж ахуйн нэгжийн үүргийг тодорхой болгож өгөх ёстой байхгүй юу. Жишээлбэл, одоо барилга барих юм бол ногоон байгууламжтай, гарц орцтой. Иргэн хүн өөрөө манай иргэд ийм байгаа шүү дээ. Машин барьж явж байгаад л дуртай газраа гэрлээ асаагаад зогсчхож байгаа шүү дээ. Түгжрэлээ үүсгээд л. Тэгээд энэ нөгөө иргэнийхээ үүрэг хариуцлагын талаар заалтаа хасаад хаячих юм энэ чинь. Ингэхээр энэ явахгүй шүү дээ. Манайд нэг ийм өвчин бий болчихоод байгаа юм. Ний нуугүй ярихад бүгдээрээ л буруутай. Бүгдээрээ л энэ замын хөдөлгөөнд оролцоод л, бүгдээрээ л энэ байдлыг бий болгочихсон байхгүй юу. Гэтэл өнөөдөр ганцхан буруутан бий болчихсон. Тэр нь энэ төр засаг л буруутай гээд ийм бий болчихсон байхгүй юу. Гэтэл энэ аж ахуйн нэгжийн үүрэг, иргэний үүрэг хаана байна. Тэрийгээ

хасах гээд байгаа байхгүй юу. Би бол харин энэ иргэний үүргийг аж ахуйн нэгжийн үүргийг маш нарийн тодотгож оруулах ёстой байхгүй юу.

Н.Энхболд: Үгүй ээ, хассанаараа ажлын хэсэг хариулсан нь дээр байлгүй дээ. Боловсруулж оруулж ирсэн төсөл дээр ийм байх ёстой гээд байж байхад манай ажлын хэсгээс хасаад ороод ирсэн байна. Ажлын хэсэгт орсон хүмүүсээс хэн нь хариулах юм. Сайнзориг өөрөө оруулчхаад, өөрөө хасчихсан юм уу. Дэмжихгүй бол тэгээд л үлдчихнэ хасах эрхтэй. Тэгэхдээ дэмжихгүй бол эд нар саяынхаар үлдэх үү. Хэн хариулах вэ. 3.

П.Сайнзориг: Яг энэ асуудлууд бас авто зогсоол болон нөгөө төлбөртэй бүсийн заалтууд бас хасагдсантай холбоотойгоор хөндөгдсөн. Тэгээд ерөнхийдөө бас ерөнхий байдлаар бас эрх, үүрэг тусгагдсан байгаа учраас шаардлагагүй гэдэг байдлаар л ажлын хэсэг дээр ярилцаад л хассан л ийм л юм байгаа.

Н.Энхболд: Тэгэхдээ ингэмээр байна. Би бол сая Тогтохсүрэн даргын ярьж байгаатай санал нэг байна. Энэ дотроосоо зүгээр тэр 24.2.2-ыг л хасчих л даа. Төлбөртэй бүстэй холбоотой яг заасан заалтаа. Бусад нь тэгээд байж байхад илүүдэх юм юу байгаа юм. Энэ чинь үүрэг, хариуцлагатай байх ёстой шүү дээ. Амараа Шадар сайд.

С.Амарсайхан: Энэ түгжрэлийн чинь ард машин, машины чинь руль дээр иргэн л сууж байгаа шүү дээ. Тэгээд тэр иргэн руль мушигж байгаа хүн хариуцлага хүлээхгүйгээр, үүрэг үүрэлцэхгүйгээр тэгээд түгжрэлийг бууруулна. Зохицуулалт хийнэ гэх юм бол яг сая Тогтохоо даргын хэлдэг энэ углуурга байхгүй юу. Иргэний үүрэг бид нар чинь одоо эрхээ мэддэг, үүргээ ярьдаггүй. Эрх нь үүргээр нь хангагддаг гэдэг ийм ухагдахууныг бий болгох талаасаа асуудалд бас хандаж энэ заалтаа бий болгохгүй бол одоо иргэний

эрх, хүний эрх ярьсаар байгаад үүргээ ярьдаг, үүргээ биелүүлдэг хүн байхгүй болсон. Тэгээд энэ иргэд чинь үүрэг, энэ хуулиар заасан зохицуулалтуудыг чинь хэрэгжүүлдэг эзэн нь болсон иргэд чинь өөрөө хариуцлага үүрч байж л энэ хууль чинь хэрэгжинэ шүү дээ. Тэгэхээр энэ заалтаа байлгасан нь дээр.

Н.Энхболд: Одоо зарчмын зөрүүтэй санал ирж байна. Одоо санал хураалгаадахъя. Ажлын хэсгийн ахлагч Амартүвшин.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга аа, энэ 26 дугаар саналын томъёолол, Төслийн 24 дүгээр зүйлийг хасах гэдгийг татаад авчихъя. Оронд нь ажлын хэсгээсээ 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтыг хасъя гэдэг саналын томъёолол оруулж ирж байна.

Н.Энхболд: 1 дүгээрт ажлын хэсгээс, 2 дугаарт Оюунчимэг гишүүн бас зарчмын зөрүүтэй санал гаргалаа. Ажлын хэсэг саналаа татаж аваад, тэгээд энэ 24 дүгээр зүйл дотроос 24.2.2-ыг нь л хасах гэдэг саналаар санал хураалгачихвал болох юм шиг байна. Тэгээд би тэрийг уншиж танилцуулъя. 24 дүгээр зүйл хэлэлцэж байна.

24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтыг хасах саналыг ажлын хэсэг, Оюунчимэг гишүүн угаасаа ажлын хэсэг үү. Ажлын хэсэг гаргаж байна. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 72,7 хувиар санал дэмжигдлээ. 24 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

25 дугаар зүйлийг хэлэлцэж байна. Ажлын хэсгээс 25 дугаар зүйлийг хасах санал орж ирсэн. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Саяын санал хураалт хүчингүй шүү. Энэ маргалдаан явж байгаад хүмүүс анзаарсангүй. Тэгээд энэ санал хураалтыг хүчингүй болголоо. Дахиад санал хураалт явуулъя. 24.2.2-ыг хүчингүй болгоё оо гэдэг санал хураалт

явуулах гэж байна. Хасах. 63,6%-аар санал дэмжигдлээ. 24 дүгээр зүйлээс нэг л заалт хасагдлаа.

25 дугаар зүйл хэлэлцэх гэж байна. Ажлын хэсгээс 25 дугаар зүйлийг бүхэлд нь хасъя гэсэн санал оруулж ирсэн байна. Асуух, санал хэлэх гишүүн байна уу. 25 дугаар зүйлийг хасах санал хураалт явуулах гэж байна. Санал хураалт 63,6 хувиар санал дэмжигдлээ. Мөнхцэцэг гишүүнийхийг дэмжсэнд тооцоорой гэж байна. Протокол оруулаарай. 25-ыг санал хурааж дууслаа.

26 дугаар зүйл дээр гишүүд, Байнгын хороодоос ирсэн санал байхгүй. Ажлын хэсгээс ирсэн санал байхгүй. 26 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

27 дугаар зүйл.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар урьдчилан найруулах:

“27.1.Энэ хуулийг 2023 оны 12 сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Ажлын хэсгийн гаргасан санал. Асуулт, саналтай хүн байна уу. Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ хугацаа аягүй шахуу байгаа байхгүй юу. 12 сарын 8 гэдэг чинь одоо 8 хоногийн дараа, 10 хоногийн дараа л гэсэн үг. Тэгээд 3 дугаар хэлэлцүүлэг хийнэ буюу эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Ёсчилно, редакц хийнэ. Дараа нь хоригийн хугацаа явна. Ингэхээр энэ аягүй юу хугацаа байхгүй юу. Манай нийслэлийнхэн хэрэгжүүлэх гэж их л яарч байгаа юм байна. Тэгэхээр хугацааны хувьд бол жаахан тийм бодитой байх хэрэгтэй байх л гэдэг л тийм л юм хэлж байгаа юм.

Н.Энхболд: Ингэж болно шүү дээ. Одоо бид нар санал гаргаж болно. Эсвэл энийгээ түрүүчийнх шиг татаж аваад, дахиад санал гаргаж болно. Эсвэл

энийгээ унагаачхаад, аль нэг гишүүн нь зарчмын зөрүүтэй санал томъёолж өгөөд тэгээд санал хурааж болно. Яах юм ажлын хэсэг. Сайнаа танай хурал чинь хэзээ билээ. Төсөв батлагдах хугацаа чинь. Амартүвшин гишүүн санал гаргая.

Г.Амартүвшин: Тогтохсүрэн гишүүний саналыг хүлээж аваад 12 сарын 8 гэдэг огноогоо өөрчилж, 12 сарын 15 болгох санал гаргаж байна. Алын хэсгээс.

Н.Энхболд: Ажлын хэсгээс түрүүчийн саналаа татаж аваад, энэ хуулийг 2023 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн томъёоллоор санал оруулж байна. Саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Нийслэл Улаанбаатар хотын 27 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Найруулгын санал. Дараа нь хамт түргэн мэдүүлсэн хуулийн төслүүд яригдана.

Найруулгын санал.

1.Төслийн “**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**” гэснийг “**ГУРАВДУГААР БҮЛЭГ**” гэж, “**ТАВДУГААР БҮЛЭГ**” гэснийг “**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**” гэж, “**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**” гэснийг “**ТАВДУГААР БҮЛЭГ**” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 9 дүгээр зүйлийн дугаарыг “8” гэж, 10 дугаар зүйлийн дугаарыг “5” гэж, 11 дүгээр зүйлийн дугаарыг “6” гэж, 12 дугаар зүйлийн дугаарыг “9” гэж, 13 дугаар зүйлийн дугаарыг “7” гэж, 14 дүгээр зүйлийн дугаарыг “10” гэж, 15 дугаар зүйлийн дугаарыг “11” гэж, 16 дугаар зүйлийн дугаарыг “12” гэж, 17 дугаар зүйлийн

дугаарыг “13” гэж, 18 дугаар зүйлийн дугаарыг “14” гэж, 19 дүгээр зүйлийн дугаарыг “15” гэж, 20 дугаар зүйлийн дугаарыг “16” гэж, 21 дүгээр зүйлийн дугаарыг “17” гэж, 22 дугаар зүйлийн дугаарыг “18” гэж, 23 дугаар зүйлийн дугаарыг “19” гэж, 26 дугаар зүйлийн дугаарыг “20” гэж, 27 дугаар зүйлийн дугаарыг “21” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Ажлын хэсэг. Санал хураалт.

Сая бид нар санал хураахдаа 24 дүгээр зүйлийг хасна гэснийг бид нар буцаагаад оруулчихсан учраас энэтэй уялдаад нөгөө дугаар юмнууд дахиад жоохон өөрчлөгдөх нь байна шүү. Үүнийг зохицуулж оруулаарай.

Одоо дагаж байгаа хуулиуд дагаж байгаа хуулиудын асуудлыг хэлэлцэнэ.

Нийслэл Улаанбаатарын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг дагаж орж ирсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. Байнгын хорооноос ч, ажлын хэсгээс ч саналгүй байга. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Мөн хуулийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна. Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга аа, энэ нөгөө авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн өөрчлөлт дээр нэг ийм л зүйл байгаа юм аа. Нөгөө цахилгаан тэжээлт автомашин гэсэн ойлголт одоо байгаа хууль дээрээ нөгөө хөдөлгүүрийн куб метрээр нь тооцож болохгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр цахилгааны тэжээлт автомашин гэдгийг тусад нь бас нэг ийм заалт оруулж ирж нөгөө татвараа тогтоох тийм шаардлагатай болчхоод байгаа юм. Бид нар одоо тэрийг сая л анзаарлаа л даа. Өөрөөр хэлбэл цахилгаан машин чинь хөдөлгүүр байхгүй юм чинь. Хөдөлгүүрийн багтаамжаар нь бол татвар, төлбөрийг нь ноогдуулж болдоггүй. Тэгэхлээр энэ дээр нэг ийм өөрчлөлт орж байгаа юм.

Н.Энхболд: Тэгээд одоо яах юм.

Г.Амартүвшин: 1 дүгээр зүйлд нь Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

11	Цахилгаан тэжээлт автомашин	0-100 000	0-80 000
----	-----------------------------	--------------	-------------

гэх юм.

Н.Энхболд: Сая энд чинь Амартүвшин гишүүн ээ, ажлын хэсгээс

санал орж ирээгүй байсан учраас бид нар хэлэлцээд, цохичихлоо шүү дээ. Тэгэхээр одоо та өөрийнхөө нэрээр томъёоллоо авч ирээд уншуул.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх.

11	Цахилгаан тэжээлт автомашин	0-100 000	0-80 000
----	-----------------------------	--------------	-------------

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “цахилгаан тэжээлт автомашин” гэснийг хасах гэсэн ийм заалт орж ирж байна. Асуух, санал санал хэлэх гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдгээр санал хураалт явууллаа шүү. Амартүвшин гишүүний оруулж ирсэн санал. Санал хураалт. Санал дэмжигдсэн шүү. Томъёоллынхоо хариуцлагыг өөрөө Амартүвшин гэж хүн хариуцаарай.

1 дүгээр зүйлээр санал хэлэлцэж дууслаа.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Араас нь дахиад юм гараад ирэхгүй биз. Байхгүй байна хэлэлцэж дууслаа. 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн, Байнгын хороо байна уу. Ажлын хэсэг байна уу. Байхгүй байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн, Байнгын хорооны санал ажлын хэсгийн санал байна уу. Байхгүй байна. Хэлэлцэж дууслаа.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Энэ хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн, Байнгын хороо, ажлын хэсэг. Ажлын хэсгээс 2 санал орж ирсэн байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 12.6 дахь хэсгийн “төлбөрийг” гэснийг “төлбөрийн орлогыг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15.9.2 дахь заалтын “боловсон хүчин” гэснийг “хүний нөөц” гэж тус тус өөрчилж, 15.10 дахь хэсгийн “, нэг өнгийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 17¹.5 дахь хэсгийн “олгоно” гэсний өмнө “энэ зүйлийн 17¹.2-т заасан журмын дагуу” гэж нэмж, 17¹.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17¹.7.Энэ хуулийн 17¹.5-д заасан хязгаарт багтаан олгох авто тээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл,

шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга батална.” Асуулт, санал байна уу. Санал хураалт. 72,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн, ажлын хэсэг, Байнгын хороо алга байна. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн, Байнгын хороо, ажлын хэсэг алга байна. 3 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Мөн хуулийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн, Байнгын хороо, ажлын хэсэг алга байна. 4 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Мөн хуулийн 5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн, ажлын хэсэг, Байнгын хороо алга байна. 5 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр нь асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгээс оруулж ирсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 10.1.10 дахь заалтыг болон мөн зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон” гэснийг тус тус хасах.

Түрүүчийн хуулиудтайгаа уялдаад орж ирсэн санал байна. Санал хураалт. 72.7 хувиар санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйл дээр дахиад санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан” гэж нэмэх. Хууль зүйн байнгын хорооноос дэмжиж оруулж ирсэн санал байна. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдэж байна.

Мөн Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.5.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 13.2.9, 22.4-т заасан үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол авто тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглоно.” Ажлын хэсгээс гаргасан санал байна. Дэмжье гэсэн санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдэж байна. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байхгүй. Байнгын хороо, ажлын хэсгээс санал орж ирээгүй. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн санал байна. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дахь зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

Төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай хүн байхгүй байна.

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай хүн байхгүй байна.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Энэ хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй.

2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Байхгүй. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр санал, асуулттай хүн байна уу. Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс 1 санал байгаа.

Төслийн 4 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хариуцсан газартай” гэснийг “хариуцсан байгуулагатай” гэж” гэж нэмэх. Ажлын хэсгийн санал. Дэмжье. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. Хэлэлцлээ.

5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцлээ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Хэлэлцлээ.

2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Хэлэлцлээ.

Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. 1 дүгээр зүйл дээр асуулт, хариулттай гишүүн байна уу. Гишүүн байхгүй байна. Ажлын хэсгээс санал орж ирсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалт буюу 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барьсан, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгах зэргээр ори, гарцыг гаргах арга хэмжээ авах.” Ажлын хэсгийн санал. Дэмжье 63,6 хувиар дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Энэ хуулийн 9.1.7-д заасан барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулна.” Ажлын хэсгийн саналыг

дэмжье гэсэн санал хураалт. 63.6 хувиар дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитектурын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-д заасан мэргэжлийн зэрэгтэй архитектур, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг нийслэлийн ерөнхий архитектурын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-д заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” Ажлын хэсгийн санал. Дэмжье 63.6 хувиар дэмжигдэж байна.

Хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирүүлсэн санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн “70 хувиас” гэсний дараа “илүүгүй” гэж, “60 хувиас” гэсний дараа “илүүгүй буюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол” гэж тус тус нэмэх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн хууль. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр саналтай хүн байна уу. Амартүвшин гишүүнийг сонсьё.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга аа, Энэ хуулийнхаа үйлчлэх хугацаа өөрчилсөнтэй холбогдуулан ер нь бол түрүүн Ганболд гишүүн бас яриад байсан Төсвийн байнгын хороон дээр санал гаргаад тэр санал нь дэмжигдээгүй юм. Тэгэхээр одоо Ганболд гишүүний Төсвийн байнгын хороо дээр гаргасан саналыг нь хүлээж аваад, хуулийг хууль салаа санаачлагчид нь буцаая гэдэг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн саналыг нь буцаая гэсэн тийм санал байгаа.

Ажлын хэсэг нь болохоор энэ хуультай холбоотой 1, 2 дугаар саналаа татаж аваад, тэгээд 3 дахь саналыг нь бол Төсвийн байнгын хороо нь дэмжээгүй саналыг нь дэмжээд харин ингээд төслийг нь хууль санаачлагчид нь буцаая гэж байгаа юм.

Н.Энхболд: Татаад авчихсан уу. Танайх 2 саналаа буцаагаад татаж авлаа шүү. Тийм ээ. Одоо 3 дахь саналыг хураах гэж байна. Төсвийн байнгын хороон дээр яригдаад Төсвийн байнгын хороо бол дэмжээгүй юм байна. Тэгэхээр дэмжээгүй саналыг нь дэмжихгүй байвал хууль санаачлагчид нь буцаана гэсэн үг шүү дээ. Зөв биз. Дээрх 2 саналаа татчихсан. Одоо төслийн хууль санаачлагчид нь буцаая гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжье. 63.6 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцлээ Ажлын хэсгээс санал байна шүү.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна.” Ажлын хэсгийн гаргасан санал. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

2.Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтыг 2024 оны 10 сарын 15-ны өдрөөс дагаж мөрдөнө.” гэсэн санал байна. Санал хураалт.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 13.7 дахь хэсгийн “зориулалтыг” гэсний өмнө “хийц, бүтээц” гэж нэмэх. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,5 хувиар. Ганболд гишүүнийх

хоцорчихсон байна шүү. Тэгэхдээ санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр мөн санал, асуулт байхгүй. Хэлэлцэж дууслаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс санал байхгүй. Би зүгээр ийм зарчмын зөрүүтэй санал гишүүний хувьд гаргаж байгаа юм. Энэ 1 дүгээр зүйлийг нь хасвал яасан юм бэ хасъя гэж. 1 дүгээр зүйл нь юу гэж байгаа вэ гэхээр нийслэл Улаанбаатар хотын аж ахуйд хамаарах төрийн үйлчилгээний албан тушаалыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батална гээд ийм заалт ороод ирж байгаа юм. Тэгээд энэ ингээд явчихаар дараа нь нөгөө Төрийн албаны тухай хуулийн ерөнхий концепцоос зөрчсөн засаг захиргааны нэгж ч байдаг юм уу, эсхүл нэг эдийн засгийн салбар, газар болгон ийм юмнууд оруулж ирээд ингээд яваад байх үүд хаалга нээгдэх байх. Зарчмын хувьд бол энэ болохгүй зүйл гэж бодож байгаа юм. Би хасах санал оруулж байгаа юм. Энэ дээр асуух хүн байна уу. Яг юу бодож энийгээ оруулж ирсэн юм. 3 дугаар микрофон.

П.Сайнзориг: Ийм байгаа юм Энхболд дарга аа, Одоо хот нийтийн аж ахуй буюу хотын захирагчийн ажлын

албан дээр удирдах албан тушаалтнууд нь ТЗ ангиллын хүмүүс байгаа. Гэтэл яг доороос нь буюу ОСНАК энэ тэр дээр ажиллаж байгаа слесарь ч гэдэг юм уу, хот нийтийн аж ахуйн тохижилт дээр ажиллаж байгаа хүмүүс ТҮ болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ерөөсөө шатлан дэвших хүн байхгүй. Тэгээд ийм учраас бид хэд энийг нь дүйцүүлж байж тэрийг нь сонгон шалгаруулалтад орох эрхийг нь нээж өгөхгүй бол ямар ч боломжгүй байгаа. Одоо болохоор ТҮ-ийн удирдах албан тушаалтнууд ийм эрхийг эдлээд байгаа шүү дээ. Ямар ч салбар дээр. Гэтэл энэ өөрөө эргээд тэр хот нийтийн аж ахуйгаар мэргэшсэн хүмүүс нь дээшийгээ удирдах албан тушаал хаших ямар ч бололцоогүй байдлаар одоогийн хууль, эрх зүй нь явж байгаа. ТАЗ-тэй бид нар зөвшилцсөн. Энийг дэмжиж байгаа гэдгээ хэлчихсэн байж байгаа. Тэгэхээр ийм л зүйл практик дээр байгаа. Одоо ингэхээр Захирагчийн ажлын албан дээр ерөөсөө битүү орон тоо дарга, цэрэг болох хүн байхгүй. Тэгээд энэ яг хот нийтийн аж ахуй дээр ажиллаж байсан хүмүүс нь ТҮ дээр ажиллаж байгаа хүмүүс ТЗ рүү шилжиж удирдах албан тушаалаа хийх боломжгүй ийм нөхцөл байдалтай ингээд хотын ажил бас жоохон хүндрэлтэй л байгаа юм. Хүний нөөцөд талаасаа.

Н.Энхболд: Энийг тал талаас нь жоохон ярья. Өөр саналтай хүн байна уу. Энэ чинь тэгээд ерөнхий зарчмаасаа л зөрчөөд байна шүү дээ. Төрийн үйлчилгээнд ажиллаж байсан хүнийг захиргааны ажилд шилжүүлж ерөөсөө болохгүй, дэвшүүлж болохгүй гэсэн заалт хаана байгаа юм. Үгүй ээ, үгүй. Тэр дээрээ хүрвэл тэгвэл заавал нийслэл Улаанбаатарын гэдэг үг энд ямар хэрэгтэй юм. Энийг ингэе. Санал хураалгаадахъя. Тэгээд чуулган дээрээс Их Хурлын даргаас чиглэл авч байгаад эсхүл нийтлэг маягаар зохицуул гэсэн маягийн юм л авах нь зүйтэй болов уу л гэж би бодоод байна. Тэгээд тэр дээрээ эсрэг болсон нэг хүн нь тайлбар хэлнэ

биз. Тэгвэл дахиад нэг яриад ир гээд чиглэл өгөөд ороод ирэг.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасъя гэсэн санал гаргаж байна. Энийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Энэ дотроос ингэж болно шүү хамаагүй. Манай эсрэг санал өгсөн хүмүүс тэр дээр нөгөө зарчмын зөрүүтэй санал гаргаад, байр сууриа илэрхийлээд цөөнх гэж байгаад үгээ хэлээд, тэгээд гүйцээх чиглэл аваад явж болно. Санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна. 2 дугаар зүйлээр хэлэлцэж дууслаа

3 дугаар зүйл дээр асуулт, санал байна уу.

4 дүгээр зүйл дээр асуулт, санал байна уу.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлбэ.

1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. 2 дугаар зүйл дээр Ганболд гишүүн.

Г.Ганболд: Энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль дээр энэ аймаг, нийслэлийн Иргэдийн Хурлын дарга нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга гээд байдаг юм л даа. Тэгээд энэ яагаад гэхээр нөгөө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд Иргэдийн хурлын тогтоолоор прокурор, шүүхийнхнийг татан оролцуулж, хуулийн

байгууллагуудыг оролцуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр бол тодорхой ажлууд хийдэг юм. Тэгээд Иргэдийн Хурлын одоо бид нар чинь өмнө нь энэ тэргүүлэгчдийг нь аваад нэг зөвлөлтэй болгочихсон. Иргэдийн Хурлын үүрэг, роль гэдэг юм бүр байхгүй болж байна л даа. Тэгэхээр энийг яг авах гээд байгаагийнхаа ач холбогдлыг нэг надад нэг хэлээд өгөөч. Яг яагаад Засаг дарга дээр байх ёстой юм. Иргэдийн Хурал дээр байхаар юу нь болохгүй байгаа юм. Засаг дарга дээр байхаар яг давуу ахиц дэвшил нь Засаг дарга бол захирамжаар прокурорыг оруулах төвөгтэй л болчихдог зүйл л дээ. Тэгэхээр уг нь энийг байна шүү дээ. Хэрвээ оруулах гэж байгаа бол нийслэл дээр ач холбогдол байгаа бол аймгуудад бол хуралд байх нь илүү ач холбогдолтой байдаг юм. Тэгэхээр энэ дээр би зарчмын зөрүүтэй санал гаргаад, түрүүний юу шиг аймаг, нийслэл гэдгийг нь салгаж явах тийм боломж байх уу дарга аа. Энэ дээр л нэг гаргамаар байх юм. Ядаж одоо нийслэл дээр тийм ач холбогдолтой байдаг юм бол орон нутаг дээр энэ аймгууд дээр бол хурал дээр нь байх ёстой л гэж бодоод байгаа юм.

Н.Энхболд: Юу ч гэсэн Сайнзориг даргын үндэслэлийг сонсчихъё. 3 номерын микрофон өгөөрэй.

П.Сайнзориг: Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажил бол Засгийн газар буюу түүний орон нутагт төлөөллийн хийх ажил байж байгаа. Гүйцэтгэх эрх мэдлийн хийх ажил. Гэтэл өнөөдөр Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх тухай хуулиар 1997 оноос явж ирсэн практикаар сангийн асуудлыг Иргэдийн төлөөлөгчдийн Хурал буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хамтын шийдвэр гаргадаг байгууллагын дэргэд ажиллаж байгаа. Энэ зөвхөн нийслэл гэлтгүй 21 аймаг тэр дундаа хамтын удирдлагын байгууллагын ИТХ-ын дарга буюу зүгээр хурлыг даргалах этгээд маань сангийн тэргүүн хийж байгаа.

Одоо энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн зарцуулалт энэ тэр дээр хийгээд явж байгаа. Тэгэхээр энэ сангийн хөрөнгө бол үндсэндээ Засаг даргын үйл ажиллагаатай уялдах буюу Засаг дарга тэр тухайн нутаг дэвсгэр дээрээ гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг Засгийн газрын өмнө хариуцлага хүлээж байгаа. Энэ хүрээндээ бас энэ асуудлыг уялдуулж шийдэж байгаа буюу нэгжийн хууль дээр ч гэсэн энэ агуулгаараа энэ эрх, үүрэг, чиг үүргүүд бас тусгагдсан байж байгаа. Үүнтэй уялдуулж орж ирж байгаа юм.

2 дугаарт, мэдээж юу гэдэг юм. Өдөр тутам үйл ажиллагаа хийж явж байгаа Засаг дарга нь энэ чиглэлийнхээ юмыг хариуцаад, чиглүүлээд явах нь бас зүйтэй гэж засаг дээр бас яригдаж ийм чиглэл өгөгдсөн. Энэ хөрөнгөөс ч гэсэн бас тодорхой хэмжээний зам тээврийн тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж сайжруулах энэ асуудлыг оролцуулъя гэдэг ийм өнцгүүд бас байгаа буюу Иргэдийн Хурлын дэргэд байхаар энэ хөрөнгийн зарцуулалт дээр хяналт тавих асуудал нь хэн байх вэ. Тэгэхээр Засаг даргынхаа дэргэд ирэхээр харин иргэдийн хурал нь Засаг даргынхаа үйл ажиллагаандаа хяналт тавих бололцоотой байдлаараа энэ чиг үүргээ хэрэгжүүлнэ л гэж байгаа юм. Тэгэхээр бас энэ агуулга буюу Үндсэн хууль болон Засаг захиргаа нэгжийн тухай хуулийнхаа сая шинэчилсэн найруулгын Засаг дарга нь юу хариуцах вэ, Иргэдийн Хурал нь юу хариуцах вэ гэдэг энэ чиг үүргийнхээ хүрээнд л энэ асуудлыг оруулж ирж байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Н.Энхболд: Асуулт асууж, санал дууслаа. Санал хураах уу. 2 дугаар зүйл дээр чинь ажлын хэсгээс санал байхгүй. Бусад Байнгын хороодоос санал байхгүй. Гишүүн санал байхгүй ббол санал хураалаа шүү Ганболд гишүүн ээ. Санал хураалт. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Ер нь сая ингэсэн юм. Зүгээр энийг ажлын хэсэг дээр энд Шадар сайд бас яриад энэ саналаа татаж авъя гэж байгаа юм. Тэгэхгүй болохоор бас нэг Иргэдийн Хурал дээр олон намын төлөөлөл байдаг. Тэгээд бас энэ урьдчилан сэргийлэх үүргийг чинь Иргэдийн Хурал дээр нь үлдээе л гэж байгаа байхгүй юу. Энийгээ татаж авъя л гэж байгаа байхгүй юу. Ажлын хэсэг хэлчихсэн нь дээр шүү дээ.

Ганболд гишүүн ээ, түр хүлээж байгаарай. Би нэг юм хэлээдэхье. 1 дүгээр зүйл дээр юм байхгүй байсан. 2 дугаар зүйл дээр хаанаас ч санал орж ирээгүй байгаа. Хэрэв санал гаргая гэвэл зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгаж болно. Ажлын хэсгээс татах санал байхгүй. Юу ч байхгүй саналгүй орж ирсэн байхгүй юу. Тэгэхээр хууль санаачлагчийнхаар л явна гэсэн үг шүү дээ. Үг хэлэх юм уу. Шадар сайд Амарсайхан.

С.Амарсайхан: Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гээд одоо Иргэдийн Хурал дээр аймаг, нийслэл дээр одоо энэ чинь нийслэлийн асуудал ярьж байгаад бид 21 аймгийнхаа асуудлыг давхар яриад явчхаж байгаа байхгүй юу. 21 аймаг, нийслэл. Тэгээд иргэдийн хурал дээрээ энэ чинь соён гэгээрүүлэх, тэгээд иргэдэд би бас Иргэдийн Хурлын дарга байсан хүний хувьд энийг яриад байгаа юм. Энэ чинь өөрөө соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх. Тэгээд өмнө нь Улаанбаатар хот дээр үүгээр чинь дамжуулаад өмгөөлөгчдийг хүртэл шаардлагатай иргэдэд, хороодод хот даяар иргэдэд үйлчлэх зохион байгуулалтын ажлыг хүртэл хийж явсан. Тэгээд ганцхан замын тэмдэг тэмдэглэгээ тавина гэдгээр ингээд яваад ирчихсэн. Явж байгаа ажлыг та нар ингэж болохгүй шүү дээ. Бүх юмыг өөрчлөөд. Тэгээд би хэлээд байгаа нь Иргэдийн Хурал гэдэг чинь өөрөө бас нутгийн өөрөө удирдах байгууллага шүү. Энэ байгууллагынхаа хэрэгжүүлж ирсэн, хийж ирсэн, зохион

байгуулж ирсэн асуудлуудаа тэгээд Засаг даргатайгаа яриад л хоорондоо та нар шийдээд явна биз. Тэрийг заавал нэг байгууллага хоорондоо ингээд л явж ирсэн юмыг булаацалдаж байгаа юм шиг, эсвэл бие биеийгээ үгүйсгэж байгаа юм шиг ийм байдлаар наадах чинь нийслэлийн асуудал биш, 21 аймгийн асуудал. Тэгээд наад төлөөлөгчид чинь бас өөрсдөө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаагаа Засаг дарга, Иргэдийн Хурал 2 хамтарч зохион байгуулж ирдэг Засаг дарга, Иргэдийн хурлын дарга сангийн тэргүүн гээд байх юм. Сангийн тэргүүн гэж юм байхгүй шүү дээ. Наана чинь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн зардал гэж төсөв дээр тусгадаг. Сан гэж ерөөсөө огт тийм юм байхгүй. Тэгээд юм мэдэхгүй хүмүүстэй ярьж байгаа юм шиг ингээд ийм сонин сонин тайлбар хийгээд, улам будилуулаад байх шаардлага байхгүй шүү дээ.

Н.Энхболд: Дэлгэрсайхан сайдын микрофон өгөөрэй.

Б.Дэлгэрсайхан: Энийг бол ойлгож байна. Тэгэхдээ энэ 2021 онд баталсан нэгжийн хуулиар бол гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг Засаг дарга, бүх аймаг, орон нутгийн Засаг даргад үүрэг болгосон учраас эндээ өөрчлөлт оруулаад, тэгээд энэ юугаа татаад авчихъя аа л гэж. Тэгэх үү. Нэгжийн хуульд өөрчлөлт оруулахгүй бол үүрэг нь бол тийм байгаа шүү. Засаг захиргаа нэгжийн хуулийг би ярьж байгаа шүү дээ. Үгүй ээ, би Ганболд оо ойлгож байна. Тэгэхдээ Засаг захиргаа нэгжийн хуульдаа хэдүүлээ энэ заалтыг нь өөрчлөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг иргэдийн хурал хариуцна гэдэг энэ заалтыг нэмж оруулаад, тэгээд энийгээ татчихъя л гэж байхгүй юу. Зөв биз дээ. Тэгээд л засагдчихъя гэж байна шүү дээ. Би ойлгож байна. Одоо орон нутагт та хэд бас өөрсдөө Иргэдийн Хуралд байсан хүмүүсийн зовлонг ойлгож байна. Тийм учраас Засаг захиргаа нэгжийн хуульдаа гэмт хэрэгтэй тэмцэх

ажлыг аймаг, орон нутгийн Иргэдийн Хурал хариуцна гэж өөрчлөлт оруулаад. Ямар ч байсан энийг татаад тэгээд яачихъя.

Н.Энхболд: Энийг татаад авах тухай асуудал байхгүй. Одоо ажлын хэсгээс санал орж ирээгүй. Өөрөөр хэлбэл үүгээрээ явъя гэж байгаа. Хажуугаас Ганболд гишүүнээс зарчмын зөрүүтэй санал орж ирж байна. Энэ дотроос тодорхой хэсгийг нь хасах гэсэн санал орж ирж байгаа учраас тэрүүгээр хураалгаад, олонх нь дэмжвэл энэ томьёолол дотроосоо Ганболд гишүүний бичсэн энэ заалтыг хасаад л үлдсэн түүгээрээ явна гэсэн үг болно.

2 дугаар зүйл дээр гишүүнээс зарчмын зөрүүтэй санал орж ирсэн уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар” гэснийг “тухайн шатны Засаг даргаар” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “Засаг дарга” гэснийг хасах. Энэ саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ чинь 54,5 хувиар энэ саяын томьёолол хэсэг нь хасагдлаа шүү. 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна. 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудал. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг зүйл зүйлээр хэлэлцэж эхэлнэ.

1 дүгээр зүйл дээр санал, асуулт байна уу. Ажлын хэсгээс орж ирсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 35.2.1 дэх заалтыг хасаж, 35.2.2 дахь заалтын дугаарыг 35.2.1 гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.1.амьтны хүрээлэн ажиллуулах журам.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6%-аар санал дэмжигдлээ.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр байхгүй. Хэлэлцлээ.

4 дүгээр зүйл дээр асуулт санал байхгүй. Үүгээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл зүйлээр хэлэлцэж эхэлнэ.

1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Тэмдэгтийн хураамж дээр ажлын хэсгээс санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтын “5 000 000-10 000 000” гэснийг “3 000 000-10 000 000” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье санал хураалт явуулъя. 63,3 хувиар санал дэмжигдэж байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

2 дугаар зүйл дээр санал асуулт байхгүй байна.

3 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

4 дээр дүгээр зүйл дээр санал, асуулт байхгүй.

5 дугаар зүйл дээр асуулт санал байхгүй.

Ингээд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн алга. Ажлын хэсгээс санал ирсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 23.6.11 дэх заалтыг хасаж, 23.6.12 дахь заалтын дугаарыг “23.6.11” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт 54,5 хувиар санал дэмжигдэж байна.

Мөн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй. Хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна. Хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр гишүүдээс санал алга байна. Ажлын хэсгээс 1 санал ирсэн.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6.2 дахь хэсгийн “12.6.3-т” гэснийг “12.6.3, 12.8-д” гэж, “татварын хэмжээг” гэснийг “татварын хувь хэмжээ” гэж тус тус өөрчлөх. Саналыг дэмжье. Санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал

дэмжигдлээ. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

Ул хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр гишүүддээ санал байхгүй. Ажлын хэсгээс 2 санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн “хүртэл” гэснийг “дуустал” гэж өөрчлөх. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “бараа” гэснийг “барилгын материал” гэж өөрчлөх. Санал хураалт. 54,5%-аар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй.

Ингээд Гаалийн албан татвараас чөлөөт тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс ирүүлсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.10.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” Саналыг дэмжье. Санал хураалт 54,5% санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. Хэлэлцлээ.

4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. Хэлэлцлээ. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйлээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр гишүүдээс санал алга байна. Ажлын хэсгээс санал орж ирсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “22.5.15, 22.5.16 дахь заалт” гэснийг “22.5.18, 22.5.19 дэх заалт” гэж өөрчилж, 22.5.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.5.19.гэр хорооллыг орон сууцжуулах сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” Ажлын хэсгийн санал. Дэмжье. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдэж байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

2 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр асуулт, саналууд алга байна. Хэлэлцлээ.

4 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна. Хэлэлцлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс гаргасан саналууд байна. Гишүүдээс гаргасан санал алга.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.” Ажлын хэсэг санал хураалтыг явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг хасаж, 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Амтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Ажлын хэсгийн санал. Дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа хэлэлцлээ.

Төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гаргасан санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 12.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хамааруулсан нийт газар нутгийн” гэсний өмнө “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд” гэж нэмэх. Ажлын хэсгийг гаргасан санал. Дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна. 2 дугаар зүйлээр хурааж дууслаа. Хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй. Хэлэлцлээ.

4 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй хэлэлцлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс оруулж ирсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэснийг хасаж, “7.6 дугаар зүйлийн 9. 10” гэснийг “7.6 дугаар зүйлийн 9 “гэж тохиолдол бүрд өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 54,5 хувиар санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс гарсан санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг хасах. Саналыг ажлын хэсэг гаргасан. Дэмжье. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“21.5.4.Энэ хуулийн 21.2.7-д заасан эрх шилжүүлэн авсан бол энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан шийдвэр гаргах.” ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье. Санал хураалт байна. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.8.1 дэх заалтын “жагсаалтын эхэнд” гэсний дараа “цахим системд хүсэлт гаргасан огноогоор” гэж нэмэх. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье. Санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.11 дэх хэсгийн “газар ашиглалтын” гэснийг “эдэлбэр газрын” гэж өөрчилж, “аймаг” гэсний дараа “сум” гэж нэмэх. Ажлын хэсгийн гаргасан санал дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. 1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа.

2 дугаар зүйл дээр асуулт, саналт байхгүй. Хэлэлцлээ.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 12.4, 12.6 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.” Ажлын хэсгээс гаргасан энэ саналыг дэмжье. Санал хураалт. Мөнх-Оргил гишүүн санал гаргая.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ төхөөрөмж гагцхилаа дарга аа, саяын санал хураалтыг хүчингүйд тооцоод, дахин санал хураалгаж өгөөч ээ гэж хүсэж байна.

Н.Энхболд: Мөнх-Оргил гишүүний горимын саналын дагуу саяын санал хураалтын дүнг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт 63,6 хувиар саналыг хүчингүй боллоо. Одоо дахин санал хураалт явуулна. 3 дугаар зүйлд оруулж байгаа ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Томьёоллыг түрүүн уншаад танилцуулчихсан. 54,5 хувиар санал дэмжигдлээ. 3 дугаар зүйлийг хэлэлцлээ.

4 дүгээр зүйл дээр санал байхгүй. Асуулт байхгүй. 4 дүгээр зүйлээ хэлэлцлээ.

5 дугаар зүйл дээр санал, асуулт алга байна. 5 дугаар зүйлийг хэлэлцлээ.

6 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй. Хэлэлцлээ.

Шинэ зүйл нэмэх санал ажлын хэсгээс оруулж ирсэн.

Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл. Энэ хууль батлагдахаас өмнө Газрын тухай хуульд

заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан газар эзэмших, ашиглах хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий этгээд уг хүсэлтийг шийдвэрлэнэ.” Ажлын хэсгийн гаргасан санал. Дэмжье. Санал хураалт. Тун дөхлөө дөө. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Нэгд авто замаа орхичихсон байна. Дараа нь явчихъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 33.1.5 дахь заалтын “хэмжээг” гэсний өмнө “жишиг” гэж нэмэх. Тухай хуулийг хэлэлцээд дууссан.

Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр ярина. 1 дүгээр зүйл дээр асуулт санал байхгүй хэлэлцлээ 2 дугаар зүйл дээр мөн асуулт санал байхгүй хэлэлцлээ 3 дугаар зүйл дээр асуулт санал байхгүй хэлэлцлээ. Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай.

Барилгын тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал гаргасан тэр нь 1 дүгээр зүйлийн 33.1.25 дахь заалтын “хэмжээг” гэсний өмнө “жишиг” гэж нэмэх санал гарсан байгаа. Энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6%-аар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байхгүй.

3 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна. Хэлэлцлээ.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Ажлын хэсгээс буцаах юм чинь энэ дээр хураах хэрэггүй биз дээ.

Ажлын хэсгээс энэ төслийг хууль санаачлагчид нь буцаах санал ирүүлсэн байна. Үүнийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Төслийг хууль санаачлагчид буцаах саналыг 57,5 хувиар дэмжсэн байна. Хэлэлцэж дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцэнэ.

Төслийн 1.2 дахь заалтыг 1.1, 1.2 дахь дэд заалт болгож, төсөл доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасгай.” Ийм заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

2.Төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 3, 4 дэх дэд заалт нэмэх:

“3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалтын орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцын байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр,

босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-д заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитектурын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хуулийн 12.1.7, 12.1.9, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1-д заасны дагуу Засаг даргын болон захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоонд ерөнхий архитектурын албан тушаалыг удирдах, гүйцэтгэх албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулсны үндсэн дээр явуулах.” ямар учиртай заалт юм байна. Ажлын хэсэг ийм санал гаргасан юм байна. Дэмжье. Ганболд гишүүнд микрофон өгье. Ганболдоо микрофоноо авч байгаад асуугаад, саналаа хэлчих.

Г.Ганболд: Энэ сүүлийн энэ заалт нь одоо яг ямар учиртай, яг ямар өөрчлөлт оруулах гээд байгаа юм. Сонгон шалгаруулалтыг явуулахдаа Нэгжийн хууль, Төрийн албаны хууль, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Засаг даргын болон Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоонд ерөнхий архитекторын албан тушаалыг удирдах, гүйцэтгэх албан тушаалд хамруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулсны үндсэн дээр явуулах гэдэг нь одоо яг юунд өөрчлөлт оруулах гээд байгаа юм? Тэр дээр чи нэг хариулт хэлээдэх дээ. Сайнзориг оо.

Н.Энхболд: 3. Сайнзориг дарга хариулт өгье. 3 номерын микрофон.

П.Сайнзориг: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ яг одоо бид нараас зүгээс гаргаагүй. Манай Тамгын газрын л зөвлөхийн багаас л гарсан юм. Угаасаа сонгон шалгаруулалт яваад тодорхой хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх юм бол чиг үүргийг давхицуулна гэж байхгүй. Тухайн албан тушаал дээр л угаасаа л хүн авахгүй л гэсэн үг л дээ. Тэгээд зайлшгүй ийм юм байх ёстой л гээд л оруулаад байгаа. Би бол бас тантай адилхан бас ойлгохгүй л байгаа. Яг үнэнийг хэлэхэд.

Н.Энхболд: Энэ 9.4-д заасан нь яг юу гэж байгаа юм. Тэрийг уншаадах та нар манай Тамгын газрынхан. Хот байгуулалтын тухай хуулийн 9.4 дэх тайлбарыг уншаадах. Заалтыг уншаадахъя. Товчлоод уншвал энэ чинь ингэж уншигдаад байна шүү дээ. Тэр хуулиудын заалтыг нь орхичихъё. Энэ сонгон шалгаруулалтыг Засаг даргын болон Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоонд ерөнхий архитекторын албан тушаалыг удирдах, гүйцэтгэх албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулсны үндсэн дээр энэ чинь ямар учиртай заалт боллоо гэж асуусан. Ажлын хэсгийн ахлагчийн саналын дагуу энэ энэ саналаа өөрөө татаж авлаа гэж байна. Бүтнээр нь гурвууланг нь татаж байгаа юм уу, сүүлийнхийгээ татаж байгаа юм уу. Тэгвэл дахиад уншихад.

Төслийн 1 дэх заалт нь доор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмнэ гэж уншаад, энэ 5 дахь заалтыг чинь бүтнээр нь хасаад тэгээд санал хураалт явуулъя. Санал хураалт санал хураалт. Ганцхан заалт байна.

3.Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/ гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Эцсийнх ёстой эцсийн 1 үлдсэн.

Ганцхан санал байгаа. 63,6%-аар санал дэмжигдлээ.

Бусад санал дээр 1 санал байна. Нийтлэг явдаг санал.

Дээрх хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшилэлийг нийцүүлж өөрчлөх. Ажлын хэсгийн санал байна. Дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хурааж дууслаа.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Гишүүддээ баярлалаа. Санал, дүгнэлтээ ажлын хэсэг унших уу. Санал, дүгнэлтээ хэн унших юм. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулган дээр хэн унших вэ. Оюунчимэг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаан дууслаа.

18.21 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ